

**ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:

1-5

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:

6-51

**1.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл,
Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан
болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл
батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр
дахь хэлэлцүүлэг/**

2-46

**2.“Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл
баталсантай холбогдуулан авах арга хэмжээний
тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

46-51

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны
06 дугаар сарын 30-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 10 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 70.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 47 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ч.Номин;
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батбаяр;
Тасалсан: Д.Пүрэвдаваа.

Нэг.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Сангийн дэд сайд Б.Хулан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, А.Энхбат, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Батцэцэг, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Н.Цэвэлмаа, мөн газрын Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Ч.Цэвэгдорж, Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан, Бодлого, төлөвлөлт, инновацын газрын дарга Х.Баярмаа, Санхүүгийн аудитын газрын Аудитын менежер Ц.Хосжаргал, Б.Долгорсүрэн, С.Нацагдорж, А.Цогбаяр, П.Чанцалдулам, Э.Энхбаяр, Д.Энхдалай, В.Эрдэнэцогт, И.Эрдэнэцэцэг, У.Оюунхүү, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал, Гадаад харилцааны дэд сайд Г.Амартүвшин, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасанням, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батбямба, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мягмарнаран, Эрчим хүний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий,

Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга О.Хуягцогт, мөн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, мөн яамны Хяналт шалгалт, дотоод аудитын газрын дарга Ч.Энх-Амгалан, Зам, тээврийн яамны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга Т.Сумъяа, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Ц.Батбаатар, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Гантөмөр, Монголбанкны менежер С.Цэрэннадмид, мөн банкны Мөнгөний бодлого, судалгааны газрын дарга Н.Ургамалсүвд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Удирдлага, төлөөллийн албаны дарга В.Дарханбаатар, Шүүхийн сахилгын хорооны ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайд З.Мэндсайхан, Төсвийн гүйцэтгэлийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Лүндэг, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Хүний хөгжил, нийгмийн бодлогын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг, Өргөдлийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Эдийн засгийн хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал, Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин нар тус тус танилцуулав.

Илтгэл болон аудитын дүгнэлт, Байнгын хороодоос гаргасан санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Б.Түвшин, Да.Цогтбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэг газрын дарга Б.Энхбаяр, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Сангийн дэд сайд Б.Хулан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Удирдлага, төлөөллийн албаны дарга В.Дарханбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батбямба, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга О.Хуягцогт нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Б.Түвшин, Х.Булгантуяа, Г.Лувсанжамц, С.Эрдэнэбат, Да.Цогтбаатар нар үг хэлэв.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 48 минутад хэлэлцэж дуусав

Хоёр.“Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Сангийн дэд сайд Б.Хулан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, А.Энхбат, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Батцэцэг, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Н.Цэвэлмаа, мөн газрын Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Ч.Цэвэгдорж, Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан, Бодлого, төлөвлөлт, инновацын газрын дарга Х.Баярмаа, Санхүүгийн аудитын газрын Аудитын менежер Ц.Хосжаргал, Б.Долгорсүрэн, С.Нацагдорж, А.Цогбаяр, П.Чанцалдулам, Э.Энхбаяр, Д.Энхдалай, В.Эрдэнэцогт, И.Эрдэнэцэцэг, У.Оюунхүү, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал, Гадаад харилцааны дэд сайд Г.Амартүвшин, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасанням, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батбямба, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мягмарнаран, Эрчим хүний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга О.Хуягцогт, мөн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, мөн яамны Хяналт шалгалт, дотоод аудитын газрын дарга Ч.Энх-Амгалан, Зам, тээврийн яамны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга Т.Сумъяа, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Ц.Батбаатар, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Гантөмөр, Монголбанкны менежер С.Цэрэннадмид, мөн банкны Мөнгөний бодлого, судалгааны газрын дарга Н.Ургамалсүвд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Удирдлага, төлөөллийн албаны дарга В.Дарханбаатар, Шүүхийн сахилгын хорооны ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Дэд хорооны дарга Д.Цогтбаатар тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Ж.Батжаргал нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн гаргасан, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагыг зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох, шалтгааныг арилгах үүрэг даалгавар өгөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	1
Бүгд	7

85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн гаргасан, Төсвийн гүйцэтгэлийг төрийн болон орон нутгийн өмчит компаниудын тайлан, аудит бусад төсөвт байгууллагуудын тайлан гүйцэтгэл, нэгдсэн тайлан, гүйцэтгэл гэсэн 3 үе шаттайгаар хэлэлцдэг болох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	4
Татгалзсан:	3
Бүгд	7

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан, 4.6 дэх заалтын “Улсын Их Хурал зөвшөөрч шийдвэрлэснээс” гэснийг хасаж, “төсөвт байгууллагуудаас бусад” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	0
Татгалзсан:	7
Бүгд	7

0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Д.Цогтбаатар: “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг найруулгын засвартайгаар нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	5
Татгалзсан:	2
Бүгд	7

71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 7 гишүүнээс 6 гишүүн дэмжиж, 85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Дэд хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 07 минутад хэлэлцэж дуусав

Дэд хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 20 минут үргэлжилж, 10 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 70.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 07 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН
ДЭД ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр,

Мягмар гараг

Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”

танхим

10 цаг 47 минут.

**ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН ДЭД
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өглөөний мэнд хүргэе. Хурал давхцаад хэсэг хугацаанд түр саатчихлаа уучлаарай. Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, дэд хорооны ирц 70 хувьтай бүрдсэн тул Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал.

Нэгдүгээрт, Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газар 2026 оны 06 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг явж байна.

Хоёрдугаарт нь “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэгдүгээр асуудал. Монгол Улсын 2025 оны төсвийн нэгдсэн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Нямтайширын Номтойбаяр Монгол Улсын Шадар сайд, Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Тилеуханы Аубакир Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сандагийн Магнайсүрэн Монгол Улсын Ерөнхий аудитор, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Дугарын Сүнжид Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Гомбосүрэнгийн Амартүвшин Гадаад харилцааны дэд сайд, Бат Эрдэнийн Хулан Сангийн дэд сайд, Дашцэдэнгийн Баасандамба Батлан хамгаалахын дэд сайд, Батаагийн Батцэцэг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Хоржавын Баярмаа Үндэсний аудитын газрын Бодлого, төлөвлөлт, инновацын газрын дарга, Найдангийн Цэвэлмаа Үндэсний

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Даваасамбуугийн Баярсайхан Үндэсний аудитын газрын Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Чимэдцэрэнгийн Цэвэгдорж Үндэсний аудитын газрын Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, тэргүүлэх аудитор, Ганболдын Нандинжаргал Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор, Заграагийн Баасанням Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга, Идэшийн Батхүү Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга гэнэ үү? Энэ чинь Шадар сайд бөгөөд Төрийн нарийн бичгийн дарга биш биз дээ? Дагвадоржийн Ганхуяг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, Батлутын Батбямба Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Буриадын Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мянгаагийн Баяраа Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Төмөр-Уяагийн Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Батмөнхийн Ерэн-Өлзий Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, Бавуужавын Мягмарнаран Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Шүрэнчулууны Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Намжилын Эрдэнэбаяр Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Адъяасүрэнгийн Батжаргал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Балдангомбын Бат-Эрдэнэ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Төмөр-Очирын Ням-Очир Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Баасангийн Батжаргал Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Цэвээнжавын Батбаатар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга, Сангидоогийн Цэрэннадмид Монголбанкны Ерөнхий менежер, Нанжидын Ургамалсүвд Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газрын дарга ирчихсэн байгаа юм уу? Гэлэгжамцын Энхтайван Гаалийн ерөнхий газрын дэд дарга, Вандангийн Дарханбаатар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татварын хураалт, арга зүйн газрын дарга, Чүлтэмсүрэнгийн Цасчихэр Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын Нарийн бичгийн дарга, Даваажавын Гантуяа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Огнонгийн Хуягцогт Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга, Чойдогдэмэдийн Энх-Амгалан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Хяналт шалгалт, дотоод аудитын газрын дарга, Төмөрбаатарын Сумъяа Зам, тээврийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Бадарчийн Ариунжаргал Шүүхийн сахилгын хорооны ерөнхий нягтлан бодогч, Нарангийн Мөнхсүх Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Чойжоогийн Гантөмөр Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга, Цэрэннадмидын Хосжаргал Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитын менежер, Баясгалангийн Долгосүрэн Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын Аудитын менежер, Сүхбаатарын Нацагдорж Үндэсний аудитын газрын Санхүүгийн газрын аудитын менежер, Агвааны Цогбаяр, Пүрэвсүрэнгийн Чанцалдулам, Эрдэнэжаргалын Энхбаатар, Доржсүрэнгийн Энхдалай, Вандангийн Эрдэнэцогт, Идэр-Арслангийн Эрдэнэцэцэг, Уламбаярын Очирхүү гээд бүгдээрээ

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн Аудитын менежер, ахлах аудиторуд хүрэлцэн ирсэн байна.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Загджавын Мэндсайхан танилцуулна. Мэндсайхан сайдын микрофоныг өгье.

3.Мэндсайхан: Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглаврын дагуу Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланг нэгтгэн боловсруулж, “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг төслийн хамт Засгийн газраас 2026 оны 06 сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлсэн.

Нэгдсэн төсвийн 2025 оны гүйцэтгэлээр тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 30 их наяд 303.2 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 33.7 хувь, нийт зарлага, цэвэр зээлийн дүн 31 их наяд 331 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 34.8 хувьд тус тус хүр, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 27.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь дотоодын нийт бүтээгдэхүүний 1.1 хувьтай тэнцэж байна.

Тайлант онд улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 18 их наяд 988 тэрбум төгрөгт хүрч, 95.9, хувийн биелэлттэй. Нийт зарлага, цэвэр зээлийн дүн 20 их наяд 414.3 тэрбум төгрөг буюу 90.5 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд 613 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, 2 их наяд 135.4 тэрбум төгрөгийн буюу 73 хувийн сая санхүүжилтийг, гадаад зээлийн тусламжийн хүрээнд 116 төсөл, арга хэмжээнд 1 их наяд 874.9 тэрбум төгрөгийн буюу 96 хувийн санхүүжилтийг, нийт 729 төсөл, арга хэмжээнд 4 их наяд 10.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, энэ хүрээнд 1800 орчим аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж ажилласнаар 110 мянган ажлын байрыг хэвээр хадгалж, улсын хэмжээнд 490 төсөл барилга байгууламж ашиглалтад орлоо.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.1, 8.10.2 дахь заалтад тус тус заасны дагуу төсвийн нэгдсэн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийлгэн улсын төсвийн гүйцэтгэлийн тэнцвэржүүлсэн орлого, зарлагын хэмжээг баталгаажуулсан болно.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Баярлалаа.

Да.Цогтбаатар: Сангийн сайд Мэндсайхан сайдад баярлалаа.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлангийн талаарх аудиторов дүгнэлтийг Монгол Улсын

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Ерөнхий аудитор Магнайсүрэн танилцуулна. Магнайсүрэн даргын 5 дугаар микрофон.

С.Магнайсүрэн: Улсын Их Хурлын Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын талаар тоймлон танилцуулъя.

1. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын талаар.

25 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хуулийн дагуу аудитыг гүйцэтгэж, Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг 30 их наяд 303.1 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 31 их наяд 331 тэрбум төгрөгөөр баталгаажууллаа.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн өмнөх оноос 5.5 хувиар өссөн. Тайлант онд төлөвлөснөөс 937.6 тэрбум төгрөгөөр тасарсан боловч Үндэсний баялгийн санд 2 их наяд 313.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөснөөс 357.4 тэрбум төгрөгөөр давуулсан байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 31 их наяд 331 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 2.4 хувиар өссөн нь улсын төсвийн урсгал зардал 4.6 хувиар, орон нутгийн төсвийн урсгал зардал 12.7 хувиар нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1 их наяд 27 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 1.1 хувьтай тэнцэж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хязгаар тогтож байгаа боловч төсвийн суурь тэнцэл 1 их наяд 113.9 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 1.2 хувьтай тэнцэж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т заасан тусгай шаардлагыг хангахгүй байна.

Засгийн газрын өрийн нэрлэсэн үнээр илэрхийлсэн үлдэгдэл 35 их наяд 407.7 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 39.4 хувьтай тэнцэж байгаа нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдлэгт заасан хязгаарт багтаж байгаа боловч нийт өрийн үлдэгдлийн 95.7 хувийг гадаад валютаар илэрхийлсэн өр эзэлж байгаа нь стратегийн баримт бичиг тогтоосон 80 хувийн зорилтот түвшнээс давсан үзүүлэлттэй байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн хүрээнд зарим төрлийн зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийг үнэлэх зорилгоор төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдээс түүврийн аргаар тоон болон чанарын мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийхэд салбарын бодлогын хэрэгжилтэд оруулах гүйцэтгэлийн гол үзүүлэлт тодорхойлогдоогүй, хүрсэн түвшин, гаргасан зардлын үр өгөөж, гүйцэтгэсэн ажлын өртөг тооцох тогтолцоо байхгүйгээс төсвийг зарцуулахдаа арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах соёл төл төлөвшихгүй төсөв тэлэх байдал ажиглагдаж байна.

Төсөв захирагчдын шилэн дансны хөтлөлт 94.2 хувь. Харин улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ, хөтөлбөр ажил үйлчилгээг гүйцэтгүүлж байгаа аж ахуйн нэгж байгууллага төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэж байгаа хуулийн этгээдүүд мэдээллийг ил тод, бүрэн байршуулаагүй, гүйцэтгэл хангалтгүй байна.

Улс төрийн намуудад олгосон төрийн санхүүжилтийн зарцуулалтын зардлын ангилал, шалгуур үзүүлэлт тодорхойгүй, хууль, журмын заалт уялдахгүй, хяналт шалгалт хийх чиг үүрэг давхардаж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлсэн 611 төсөл, арга хэмжээний 80 хувь буюу 6 их наяд 981.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 415 төсөл нь боловсрол, зам тээвэр, хот байгуулалт, эрүүл мэнд, эрчим хүч гэсэн тэргүүлэх 5 чиглэлд төвлөрсөн нь суурь дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, ашиглалтад хүлээн авах, хөрөнгөд бүртгэх үе шат бүрд захиалагч, хяналт хэрэгжүүлэгч, хүлээн авах комисс зэрэг холбогдох байгууллага, байгууллага, албан тушаалтнуудын хяналт, хариуцлага сул байгаагаас шалтгаалан зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу хэрэгжихгүй байх, хугацаа хоцрох, дутуу хийгдэх, чанар, стандартын шаардлагад нийцээгүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх, байнгын ашиглалтад хүлээн авах, бүртгэл хийхгүй байх зэрэг алдаа зөрчлүүд буурахгүй байгааг таслан зогсоох, арилгахад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг төрийн байгууллагын шат шатад авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзлээ.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар Улсын Их Хуралд 3 асуудлыг толилуулж, Ерөнхий сайдад 5, Шадар сайдад 1, Сангийн сайдад 9, Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 4, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад 1, Зам, тээврийн сайдад 1, бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарт 4 зөвлөмжийг тус тус хүргүүлээд байна.

2. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын талаар.

Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, Нийгмийн болон Эрүүл мэндийн даатгалын сан болон Төсвийн ерөнхийлөн захирагчийн 60 санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэдгээрийн харьяа байгууллагуудын 6792 санхүүгийн тайланг аудитад хамруулсан. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитор өөрчлөлтгүй 32, хязгаарлалттай 28 дүгнэлт өгсөн бөгөөд Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт өглөө.

Тус аудитаар Монгол Улсын Ерөнхий сайдад 6, Сангийн сайдад 2, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдад 1, бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарт 2 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.

Дээр дурдсан аудитын дүн, дүгнэлтээс үндэслээд дараах асуудалд анхаарал хандуулах шаардлагатай гэж үзлээ.

1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа төсвийн хүрээний мэдэгдэл дагуулан өөрчлөлт оруулдаг зөрчил давтагдан гарч байгаа нь төсвийн бодлого тогтвортой хэрэгжихгүй байх эрсдэл үүсгэн, төсвийн гүйцэтгэл, хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг хангахад бүрэн чиглээгүй, нийгэм эдийн засагт үзүүлэх ач холбогдлыг бууруулж байна.

2.Түүхий эдийн мөчлөг сөрсөн төсвийн тэлэлтийг хязгаарласан, орлогын бүтцийг тогтворжуулах бодлогыг хэрэгжүүлэхгүйгээр экспортын биет хэмжээнд найдсан төсвийн төлөлт хийсээр байгаа нь нийлүүлэлтээс шалтгаалсан түүхий эдийн үнэ буурах, төсвийн орлого хуваарийн дагуу бүрдэхгүй байх эрсдэлтэй байна.

3.Төсвийн орлого тасарсан, тайлант оонд хэрэгжсэн зарим хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг бүрэн олгоогүйгээс дараа оны төсөвт ачаалал үүсгэж, төлөвлөгдсөн төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

4.Орон нутгийн төсвийн орлого өмнөх оноос 7.2 хувиар, зарлага 12.6 хувиар нэмэгдсэн нь орлогын өсөлтөөс давсан зарлагыг хязгаарлаж санхүүгийн сахилга батыг сайжруулах шаардлага байгааг харуулж байна.

5.Улсын хөгжлийн бодлогын баримт бичиг, төсвийн төлөвлөлтийг үр дүнд чиглүүлэхээр зохицуулсан боловч тухайн жилийн төсвийн тухай хуулиар хөтөлбөр, арга хэмжээг зардалтай уялдуулан батлаагүй, суурь түвшин, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг оновчтой тодорхойлоогүй, хэмжигдэхүйц бус төлөвлөснөөс хэрэгжилтийг үнэлэх, үр дүнд суурилсан төлөвлөлтөд шилжих боломжийг хязгаарлаж байна.

6.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, бүртгэх, үр дүнг үнэлэх үе шат бүрд төсвийн ерөнхийлөн захирагч болон оролцогч байгууллага, албан тушаалтнуудын хяналт, хариуцлага сул, хамтын ажиллагаа хангалтгүй байгаа нь хамтын ажиллагаа хангалтгүй байгаа нь үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

7.Гадаадын дамжуулан зээлээс олон жилийн насжилттай, хугацаа хэтэрсэн, эргэн төлөлт хийгдээгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй авлагын асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу үе шаттай шийдвэрлэх шаардлагатай байна гэж үзлээ.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан, Байнгын хороодод танилцуулсан болно.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Да.Цогтбаатар: Магнайсүрэн даргад баярлалаа.

Монгол Улсын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74.4.2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Их Хурлын Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

2025 оны санхүүгийн нэгдсэн тайланг хэлэлцэж, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд ирүүлснийг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Одоо Байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулна. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лүндэг танилцуулна. Лүндэг гишүүний микрофоныг өгье.

С.Лүндэг: Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Байнгын хороодод шилжүүлсэн.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулахад Улсын Их Хурлын гишүүн Наранбаяр төсөв төлөвлөхдөө хүү, торгуулийг орлогын үндсэн эх үүсвэр болгон төлөвлөх нь жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч нарт дарамт үүсгэж байгаа эсэх, Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагууд төлөвлөснөөсөө өсгөсөн буюу давсан орлого олж, төлөвлөсөн орлогоо давуулан биелүүлсэн нь орлогын төлөвлөгөөг үндэслэлгүйгээр багасгаж тусгаснаас болсон эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн Монгол Улсын төсвийн гүйцэтгэлийн хэлэлцэж байгаа хуулийн хугацаа болон хэлэлцэх дэгтэй холбоотой санал байгаа эсэх, мөн аудитын байгууллагаас төсвийн ерөнхийлөн захирагч нарт санхүүгийн болон сахилгын хариуцлага хүлээлгэсэн тохиолдол байгаа эсэх, Сангийн яамнаас төсвийн алдагдлыг хэрхэн санхүүжүүлсэн талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн төсвийн гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах, хариуцлагатай, үр дүнтэй байлгах зарчмын хүрээнд нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хуулийн хугацааг 4 дүгээр сар болгох, Улсын Их Хурлын гишүүдэд нарийвчлан судалж, танилцах боломжийг уртасгах, мөн нээлттэй хэлэлцүүлэг болон сонсгол зохион байгуулж, иргэдэд төсвийн гүйцэтгэлийг хянах, хариуцлагын тогтолцоог бий болгох зэрэг төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэх хугацаа болон дэгийн дэгийг сайжруулах талаар санал боловсруулж, Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганаас өмнө танилцуулах талаар санал хэлсэн болно.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4.2-т заасны

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлж байна.

Дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Да.Цогтбаатар: Лүндэг гишүүнд баярлалаа.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар танилцуулна. Наранбаатар даргын микрофоныг өгье.

Н.Наранбаатар: Дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Байнгын хороодод шилжүүлсэн билээ.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Мандхай төлөвлөсөн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, хоцрогдол гарсан бол түүний шалтгаан, хүнсний салбарын ашиг шим, газар тариалан, мал аж ахуйн газар нутгийн ашиглалтын үр дүн, Хүнсний хувьсгалыг хэрэгжүүлснээр дотоодын үйлдвэрлэл болон хүнсний хангамжид бодит үр дүн гарсан эсэх, Цагаан алт хөдөлгөөний хүрээнд ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн хүчин чадал, малчдын орлого нэмэгдсэн эсэх, түүнчлэн 2025 онд Жижир, дунд үйлдвэрлэлийн сангаас олгосон нийт зээлийн хэмжээ, хөнгөлөлттэй зээл, батлан даалтын дэмжлэгт хамрагдсан аж ахуйн нэгжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайхан 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаас харахад урсгал зардлыг эзлэх хувь төлөвлөснөөс 4 нэгж хувиар өсөж, 77 хувьд хүрсэн үзүүлэлт нь Төсвийн тухай хууль болон төсвийн сахилга баттай хэрхэн нийцэж байгаа талаар, аж ахуйн нэгжүүд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах сонгон шалгаруулалтад тэнцэж, ажил, үйлчилгээ гүйцэтгэхдээ төсөвт өртгөө удаа дараа нэмэгдүүлсэн, зураг төсөл, гүйцэтгэлтэй

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

холбоотой ноцтой асуудлууд гарч байгаад хариуцлага тооцож байгаа эсэх, энэ асуудалд Тогтвортой байдлын зөвлөл, Үндэсний аудитын газар зөвлөмж, дүгнэлтээ тусгасан эсэх, хяналт хариуцлагын тогтолцоог сайжруулах чиглэлээр ямар арга хэмжээ авч байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Батчимэг 2025 оны төсвөөс олгосон татаасны нийт хэмжээ бүх салбарт өсөж байгааг дурдаад олгосон санхүүжилтийн үр дүнд нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл нэмэгдэж байгаа эсэх, төрийн болон хувийн хэвшилд олгосон татаас үр дүнд свот дүн шинжилгээ хийж, гүйцэтгэлд хяналт тавьж байгаа эсэх, мөн хөдөө аж ахуйн хүнсний үйлдвэрлэл, Шинэ хоршоо, Цагаан алт зэрэг хөтөлбөрүүдэд олгосон хөнгөлөлттэй зээл, татаас нь эдийн засгийн өсөлт, үйлдвэрлэл, ажлын байр нэмэгдүүлэхэд бодитой үр дүн авчирсан эсэх, үнэт цаас худалдан авах, батлан даалт гаргах зорилгоор олгосон 5 тэрбум төгрөгийн татаасны зарцуулалт, зориулалт, үр дүнгийн талаар тус тус асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн Мандхай баталсан төсөв хөтөлбөрөө хэрэгжүүлж чадаагүй яам, төсвийн ерөнхийлөн захирагчид батлагдсан санхүүжилтээ ашиглаж чадаагүй нь системийн түвшний доголдол үүссэн. Хүнсний хувьсгал, Цагаан алт, Шинэ хоршоо зэрэг томоохон хөтөлбөрийн зорилт, үр дүн, хэмжих үзүүлэлт нь тодорхойгүй байгааг анхаарч, төсвийн хөрөнгө оруулалт, татаас, хөнгөлөлттэй зээлийн үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг бодитой, ойлгомжтой болгох шаардлагатай. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон Сангийн яамнаас төсвийн гүйцэтгэлийн чанар, үзүүлэлтийн бодит байдлыг хэрхэн үнэлж байгаа, цаашдаа 2026-2028 оны төсвийн төлөвлөлтөд энэ доголдлыг арилгах талаар үг хэлэв.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Да.Цогтбаатар: Төсвийн байнгын хорооны дарга Наранбаатар даргад баярлалаа.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганзориг танилцуулна. Ганзориг гишүүний микрофоныг өгье.

П.Ганзориг: Дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон бусад Байнгын хороонд шилжүүлсэн.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийлээ.

Байнгын хорооны хуралдаанаар төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах үед Монгол Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун гүйцэтгэлийн аудитын дүгнэлт гаргуулах шалгуур үзүүлэлт, олон улсын гэрээ, конвенцын аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглах боломж, төрийн захиргааны төв байгууллагын хүртээмжийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, 3 яамны хамтын ажиллагааны Ай Си Эф буюу хүний эрүүл мэндийн байдал, үйл ажиллагааны чадавх, нийгмийн оролцоо болон орчин нөлөөллийг цогцоор нь үнэлэх олон улсын ангиллыг нэвтрүүлэх асуудлын талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар боловсролын салбарын хүртээмжийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар, Үндэсний баялгийн санд хийсэн гүйцэтгэлийн аудит, хяналт шинжилгээ, хариуцлагын тогтолцоо, Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг зарцуулахтай холбоотойгоор бий болсон үр дүнгийн талаарх тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Рэгдэл Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, хөрөнгө оруулалтын хугацаа, үнийн өсөлт, гүйцэтгэлийн аудитын шалгуур үзүүлэлтүүдийг хэмжигдэхүйц, бодитой болгох талаар, Улсын Их Хурлын гишүүн Зулпхар худалдан авах ажиллагаа, тендер шалгаруулалт, хууль тогтоомж, журамд нийцсэн, ил тод, шударга, үр ашигтай, явагдсан эсэх тал дээр хяналт тавих, үнэлгээ хийх тогтолцоог боловсронгуй болгох, хөрөнгө оруулалтын төсвийг шийдвэрлэх асуудалд онцгой анхаарах, шинэ нөхцөл байдалд хөгжлийн чиг хандлагатай уялдуулан ажиллах боломжийг бүрдүүлэх эрх зүйн зохион байгуулалтын нөхцөлийг нэвтрүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен барилга байгууламжийн ажлын тендер авч хэрэгжүүлж байгаа боловч гэрээт хугацаанд ашиглалтад оруулдаггүй барилгуудад хариуцлага тооцох, улмаар тэдгээрээс улсын төсөвт учирч буй ачааллыг бууруулах арга хэмжээ авах, эрүүл мэндийн салбарын өр төлбөр, эмийн санхүүжилтийн хүрэлцээ хангалтгүй байгаагаас эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар сөргөөр нөлөөлж байгаа талаар, түүнчлэн эмнэлгийн байгууллагуудын тоног төхөөрөмжийн хангамж, хүний нөөцийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх талаар тус тус санал хэллээ.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 74 дүгээр зүйлийн 74.4.2-т заасны дагуу Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, 2025 оны Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж, санал, дүгнэлтээ Төсвийн хяналтын зарлагын дэд хороонд хүргүүлж байна.

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Да.Цогтбаатар: Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Ганзориг даргад баярлалаа.

Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц танилцуулна. Лувсанжамц гишүүний микрофоныг өгье.

Г.Лувсанжамц: Дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлдүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Байнгын хороодод шилжүүлсэн.

Өргөдлийн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийлээ.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулахад Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ Үндэсний аудитын газар өөрсдийн түвшинд ажиллаж, аливаа зөрчил, хийдэл хууль зөрчсөн асуудлыг гаргаж тавьдаг боловч гаргасан зөвлөмж, дүгнэлтээр арга хэмжээ авах, шууд хариуцлага тооцох боломжгүй байгааг Улсын Их Хурлын гишүүд анхаарах, аудитын газрын чадамжийг хэрхэн нэмэгдүүлэх талаар төрийн өмчийн компаниудын удирдлагуудын хэт өндөр цалин, урамшууллын ямар хэмжээний ажлын бүтээмжийг үнэлж олгосон талаар, мөн гадаад зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдэд нарийвчилсан аудит хийгддэг эсэх болон Байгаль орчин, уур амьсгалын яам нь гадаад зээл, тусламжаар хэрэгжиж байгаа хэдэн төсөл, хөтөлбөр байгаа, тус яам 2024-2025 онд ямар дүгнэлт авсан талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун 2025 онд элсэлтийн ерөнхий шалгалт зохион байгуулахад зарцуулсан төсөв болон нийт хэдэн хүүхэд элсэлтийн ерөнхий шалгалтад хамрагдсан, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хэдэн хүүхэд байсан. Тус төсөвт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан орчин бүрдүүлэх хүртээмжийн тохиргооны төсвийг хэрхэн тооцож тусгасан талаар, дээд боловсрол эзэмшиж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо болон их, дээд сургуулиудын хүртээмжийн шинэчлэл ямар түвшинд явж байгаа талаар, мөн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээний

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хүрээнд ажлын байран дахь үйлдвэрлэлийн осол, гэмтлийг бууруулахаар тусгасан боловч тайланд 2 дахин нэмэгдсэн байгаагаас хэдэн иргэн насан туршийн хөгжлийн бэрхшээлтэй болсон. Цаашид ямар арга хэмжээ авах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа улсын төсөв, жилийн хөгжлийн төлөвлөгөөнүүдэд иргэдийн өргөдөл, санал, хүсэлтийг хэрхэн тусгаж ажиллаж байгаа талаар болон аудитын байгууллага 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн хэдэн төсөл, арга хэмжээг төсөвт өртөг нь нэмэгдэхээс хамгаалж ажилласан талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал 2025 онд Боловсролын зээлийн сангийн зээл, тэтгэлэг, буцалтгүй тусламжид хэдэн иргэн хамрагдсан болон зээлийн эргэн төлөлтийн талаар, төсвийн гүйцэтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авлаа.

Өргөдлийн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4.2-т заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцсэн талаарх Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Да.Цогтбаатар: Лувсанжамц гишүүнд баярлалаа. Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Заяабал танилцуулна. Заяабал даргын микрофоныг өгье.

Б.Заяабал: Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга, дэд хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Байнгын хороодод шилжүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хороогоор тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Мандхай Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хангалтгүй байдал, бодит гүйцэтгэл ба тайлангийн үнэлгээний зөрүү, хүнс, хөдөө аж ахуйн салбарын төсвийн хэрэгжилтийн талаар, мөн төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнээс тасарч, хөрөнгө оруулалтын төсөл,

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хөтөлбөрүүд хэрэгжээгүйгээс улсын эдийн засаг, ажлын байр, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэлд үзүүлэх нөлөөллийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулахын тулд цаашид ямар бодлого, арга хэмжээ явуулах талаар, Улсын Их Хурал гишүүн Жаргалан төсвийн сахилга бат, аудитын дүгнэлтээр илэрсэн зөрчилд хариуцлага тооцож байгаа эсэх, хөгжлийн төлөвлөгөө ба төсвийн уялдаа, төсвийн орлогын бодит бус төлөвлөлт, татварын өрийн өсөлт, мөн Засгийн газрын өрийн тогтвортой байдал ба ханшийн эрсдэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Очирбат төсвийн тусгай шаардлагын хэрэгжилт, аудитын дүгнэлтэд үндэслэн хариуцлага тооцох асуудал, төсвийн орлого тасарсан үед аж ахуйн нэгжүүдээс 1.2 их наяд төгрөгийн татварыг урьдчилан төвлөрүүлсэн ажиллагаа нь хууль зүйн үндэслэл, үүнд хамрагдсан компаниудын талаарх мэдээлэл, мөн эдийн засгийн өсөлт иргэдийн амьдралд бодитоор хүрч байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Жавхлан Төсвийн тухай хуулийн 57.3-д заасан зохицуулалт нь төсвийн сахилгад том эрсдэл учруулж байгаа талаар дурдаад, орон нутгийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг дараа жил шилжүүлэн зарцуулах одоогийн зохицуулалтыг өөрчлөх шаардлагатай талаар Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Үндэсний аудитын газар болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс тодруулан асуулт асууж, хариулт авлаа.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Очирбат төрийн аудитын байгууллагын дүгнэлтэд дурдсан 1.2 их наяд төгрөгийг аж ахуйн нэгжүүдээс урьдчилан төвлөрүүлсэн талаарх татварын асуудлаар Засгийн газар, Сангийн яам нь Үндэсний аудитын газар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зөвлөмж, дүгнэлтийг хэрэгжүүлдэггүй талаар, Улсын Их Хурлын гишүүн Жавхлан Төсвийн тухай хуулийн 57.3 дахь заалтыг шинэчлэх шаардлагатай талаар, орон нутгийн төсвийн сахилга бат, улсын нэгдсэн төсвийн удирдлагыг сайжруулах чиглэлээр эрх зүйн шинэчлэл хийх шаардлагатай талаар тус тус үг хэллээ.

Эдийн засгийн байнгын хороо Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн. Тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлж байна.

Дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Да.Цогтбаатар: Заяабал даргад баярлалаа.

Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Ардын намын бүлгийн дарга Батжаргал дарга танилцуулна. Батжаргал даргын микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн байгуулалтын байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны гүйцэтгэл,

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгдсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулахад Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа төлөвлөгөө гүйцэтгэлийн тайлангуудын хэлэлцүүлэхэд үр дүн бүтээмжгүй байгааг эргэн харах, төсвийн гүйцэтгэлийг зөвхөн Төсвийн байнгын хороогоор хэлэлцүүлдэг болох, төсвийн зарлагын эх үүсвэрийг нөхөж өглөг үүсгэж байгаа нь төрийн санд хүндрэл үүсгэж болзошгүйг анхаарах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам төсвийн төлөвлөлт, хөрөнгө оруулалт дээр анхаарч сайжруулах, санхүүжилтийн гүйцэтгэлээ авч чадахгүй байгаа төслүүд, сургууль, цэцэрлэг барих тендер зарлах хугацаа хоцорч хаагдаж байгааг анхаарах шаардлагатай талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэж, шийдвэрлэхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Да.Цогтбаатар: Батжаргал даргад баярлалаа.

Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг би өөрөө уншиж танилцуулна.

Дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Байнгын хороодод шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгдсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлэг явуулахад Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар асуулт асууж, хариулт авч, Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, Баасанжаргал, Д.Цогтбаатар нар үг хэлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа гэнэ.

Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшин танилцуулна. Түвшин гишүүний микрофоныг өгье.

Б.Түвшин: Эрхэм дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 06 сарын 17-ны өдрийн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Улсын Их Хурлын Байнгын хороодод шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2026 оны 06 сарын 24-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлгийг явууллаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 2025 онд 33179.2 тэрбум төгрөгт хүрч, Төсвийн тогтворжуулалтын санд 562.5 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 1710.6 тэрбум төгрөг, Хуримтлалын санд 602.9 тэрбум төгрөгийг тус тус хуваарилсан байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 30303.2 тэрбум төгрөг, нийт зарлага болон цэвэр зээлийн нийлбэр дүн 31331 тэрбум төгрөг болж, тэнцвэржүүлсэн тэнцэл 1027.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь дотоодын нийт бүтээгдэхүүний 1.1 хувьтай тэнцэж байна.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах үеэр Улсын Их Хурлын гишүүн Дав.Цогтбаатар төрийн аудитын байгууллагын дүгнэлтэд тусгагдсан зөрчил, дутагдлыг бууруулах, төсвийн хөрөнгө болон өр төлбөрийн удирдлагыг сайжруулах, санхүүгийн бүртгэл, тайлагналын чанар, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар, мөн 10 аймгийн дулааны станцын төслүүдийг бүрэн дуусгах, ашиглалтад оруулах талаар асуулт асууж, хариулт авлаа.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин төсвийн орлогын өсөлтийг хөрөнгө оруулалтаас илүүтэй урсгал зардалд зарцуулж буй тогтолцоо, эдийн засгийн хөгжлийг хязгаарлаж байгааг онцлон урсгал зардлыг бууруулж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, төсвийн бүтцэд бодит өөрчлөлт хийх шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Дав.Цогтбаатар төсвийн

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

гүйцэтгэлийн хэлэлцүүлгийг үр дүн төвлөрсөн байдлаар зохион байгуулах, татварын ачаалал нэмэгдэж зүйн нөхцөлд төсвийн зарлагын сахилга, хариуцлагыг бэхжүүлэх, иргэдийн татварын дарамтыг бууруулах арга хэмжээ авах талаар үг хэлэв.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд. Баярлалаа.

Да.Цогтбаатар: Байнгын хорооны санал дүгнэлттэй танилцаж дууслаа.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн талаар Сангийн сайдын илтгэл болон аудитын тайлантай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Түвшин гишүүнээр тасаллаа. Лувсанжамц гишүүний микрофоныг өгье.

Г.Лувсанжамц: Сайн байцгаана уу? Сангийн яамнаас үр дүнгийн талаар асуух гэсэн юм. Төсвийн гүйцэтгэлийн үнэлгээ гээд хөтөлбөр үр дүнгийн 2025 оныг хавсралтаар харахлаар төсвийн ерөнхийлөн захирагч нар маань шалгуур үзүүлэлтийгээ тавиад хамгийн ард нь төлөвлөсөн төсөв, зарцуулсан төсөв гэж тавьж байгаа юм. Зарцуулсан төсөв нь тухайлбал Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр 84 хувьтай гэсэн ийм өндөр тоонууд гарч байгаа. Энэ 84 хувиар үнэлэхлээр энэ байгууллага сайн ажиллалаа гэж Сангийн яаман дээр дүгнэх үү, эсвэл шалгуур үзүүлэлт буюу хөтөлбөрийн үр дүн нь ахисан байх юм бол сайн ажиллалаа гэж дүгнэх үү? Одоо тавьчихсан байгаа хуваарь харах юм бол 90 хувь зарцуулсан, 96 хувь зарцуулсан, мөнгөө үрээд дуусгасан учраас сайн ажилласан гэсэн ийм төсвийн ерөнхийлөн захирагч нарын тоо харагдаж байгаа. Энэ бусад 35 төсвийн ерөнхийлөн захирагч нар энийг яаж дүгнэж байгаа вэ? Цаашдаа энэ тайлан гарч ирэхдээ 100 хувь зарцуулаад дуусчихсан 100 хувийн амжилт чанартай байна гэсэн төсвийн ерөнхийлөн захирагчид ирэх жилийн төсвийг нь тооцохдоо хөтөлбөрийн үр дүнг нь тооцоолж байж төсвийг нь тавьж өгөх үү? Намар өргөн барих төсөв дээр энэ дээр ямар ажиллагаатай байгаа гэдэг эхний асуулт.

Хоёрдугаарт нь Б.Энхбаяр сайд байгаа учраас асууя. Өмнө нь нэгдсэн чуулган дээр бас танаас асуулт асуугаад хариулт авч чадаагүй. Таван жилийн үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлтээр төсвийн ерөнхийлөн захирагч нарын үр дүнг энэ жилээс эхлээд тайлагнана. гэсэн Их Хурлын тогтоолын төслийг өнгөрсөн 11 сард баталсан. Энэнийхээ дагуу асуултуудыг асууж байгаа. Өмнө нь хөгжлийн

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

төлөвлөгөө ярихад ч гэсэн бүх төсвийн ерөнхийлөн захирагчид энэ дээрээ бэлтгэлтэй байгаа гэдгээ хэлсэн.

7.3.5.1.Төрийн өмчит болон төрийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгийн өгөөжийг хэдэн хувь байгаа вэ 2025 оны гүйцэтгэлээр? Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгийн өгөөжийг тооцох гэж оруулж ирсэн. Бүтэн жилийн хугацаанд та хэд маань тооцсон уу? Таны хувьд нийтдээ 96 тэрбум төгрөг танай байгууллага төсөвлөгдөөд 82 тэрбум төгрөгийг зарцуулсан буюу 85 хувиар нийт төлөвлөсөн төсвөө зарцуулж дууссан гэж байгаа. Энэ 82 тэрбум төгрөгөөр төрийн өмчит компаниудын хөрөнгийн өгөөж сайжирсан уу?

Да.Цогтбаатар: Болчихсон уу? 2 номерын микрофон.

Б.Хулан: Дэд хорооны гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Сангийн дэд сайд Хулан. Лувсанжамц гишүүний Сангийн яамтай холбоотой асуусан асуултад хариулъя.

Тэгэхээр ер нь бол нөгөө гүйцэтгэлийг бол харуулахдаа төсвийн төсөөлөл тэгээд гаргасан гүйцэтгэл гээд энэ бол зөвхөн санхүүгийн буюу төсөвлөл талаасаа хэдэн төгрөг төсөв төсөвлөсөн юм, түүнийг гүйцэтгэл нь гэдэг энэ үр дүн байгаа. Тэгэхээр нөгөө “output”, “outcome” буюу яг хүрэх үр дүн Кэй Пи Ай болон тухайн төсөл, арга хэмжээ, хөтөлбөр, хөрөнгө оруулалтад зориулсан төсөвлөлтийг гүйцэтгэлийн дагуу гаргах үүрэг нь бол Сангийн яамны үүрэг байдаг.

Түүнийг Кэй Пи Ай-жуулах байдаг юм уу, эсвэл нөгөө илүү үр дүнг нь яг юугаар хэмжих юм, яаж хэмжих юм, хэдэн давхарга байх юм гэдэг нь цааш цаашдаа ингээд нэгдсэн төсвийнхөө төлөвлөлт, гүйцэтгэлтэй уялдаад бусад бас Эдийн засаг, хөгжлийн яам болон бусад байгууллагуудтайгаа хамтраад явах ийм агуулгатай байгаа юм.

Тэгэхээр та гүйцэтгэлийг бас асуулаа. Тухайлан Засгийн газрын Хэрэг эрхлэх газар гэж асууж байх шиг байна. Тэгэхээр Хэрэг эрхлэхээс бас төлөөлөл байгаа учраас хариулах нь зүйтэй байх гэж бодож байна.

Сангийн сайдын тухайд бол төсвийн гүйцэтгэлээр асуухад энэ гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсвүүд бол Сангийн сайдын багцад суудаг учраас энэ дээр бас тийм агуулга давхар байгаа байгаа шүү гэдгийг бас хэлье.

Да.Цогтбаатар: 2 номер дээр сууж байгаа хүн чинь Сангийн дэд сайд тээ? Та асуултаа ойлгохгүй байгаад байх шиг байх юм. Мөнгөө үрээд дуусчихсан гэдэг чинь ажлаа хийгээд дуусчихсан гэсэн үг юм уу л гэж асуугаад байгаа шүү дээ. Цаашдаа яах чинь хамаагүй.

Б.Хулан: Тэрийг нь харин биш гэж хэлж байгаа юм.

Да.Цогтбаатар: Та хэд мөнгө үрж байгаа, мөнгө барьж байгаа яамны сайд, дэд сайд, яамны удирдлагууд шүү дээ. Мөнгөө үрчихсэн чинь ажлаа хийгээд дуусчихсан гэж үзээд байгаа юм уу гээд маш тодорхой асуугаад байна.

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Б.Хулан: Тэр бол ажлаа хийгээд дууссан гэж үзэх хэмжүүрүүдийн нэг нь бол мөн. Түүнээс бүтнээрээ ямар үр дүнд хүрсэн юм, хэдэн ажлын байр нэмэгдүүлсэн юм гэдэг юм уу тухайн төсөл, хөтөлбөрийнхөө хүрээнд хүрч байгаа үр дүн нь бол зөвхөн дан ганц зарцуулалт нь гарсан гэдгээр 100 хувь хэмжигдэхгүй л гэж хэлж байгаа юм.

Да.Цогтбаатар: Энхбаяр сайд. Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Төрийн өмчийн компанийн эрх зүйн орчны асуудал дээр ер нь Их Хурлын гишүүд бас бүгд энэ асуудал дээр чуулган, Байнгын хорооны хэлэлцүүлгийн шатанд бол гол хөндөж асууж байсан. Үнэхээр манайд таны хэлсэнчлэн төрийн болон орон нутгийн өмчийн компаниудын үр өгөөжийг бодитой тооцох гэхээсээ гадна ер нь манайд энэ орон нутгийн өмчийн хэчнээн компани ямар бүтэцтэй яаж ажиллаж байна вэ гэдгийг нэгдсэн байдлаар тоолоод үзээд явж байгаа ийм асуудал хүнд байгаа. Та бүхэн ч гэсэн Улсын Их Хурлын чуулганы явцад Төрийн өмчийн хорооноос асууж байхад яг төрийн.../минут дуусав./

Да.Цогтбаатар: Энхбаяр сайдын микрофоныг нэмж өгье.

Б.Энхбаяр: Энэ чинь 1 минутаар юм уу. Орон нутгийн өмчийн компаниудынхаа тоог ч гарахад хүнд байгаа. Нийслэл бол 100 гаруй компани гээд байгаа. Дүүргүүд бас хэчнээн компаниуд түүгээрээ байгуулаад юу болж байгаа гэдэг юмыг улсын хэмжээнд нэгтгэх боломж хийж байсан ажил байхгүй байгаа. Засгийн газар бол олон хоног болгон төрийн өмчийн компанитай холбоотой асуудлыг авч үзэж байна. Тун ойрын үед Монгол Улсын Ерөнхий сайдын манлайлал дор төрийн болон орон нутгийн өмчийн компаниудыг нээлттэй олон улсын хөндлөнгийн аудит хийж, нээлттэй компани болгох санамж бичиг наадмын өмнө зурагдах гэж байгаа.

Энэ хүрээнд бүх чиглэлд үндэсний биш олон улсын аудит орох, ингээд олон нийтийн хяналтад оруулна. Тэгж байж бид нар сая.../минут дуусав./

Да.Цогтбаатар: Лувсанжамц гишүүн тодруулъя.

Г.Лувсанжамц: Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яамнаас хоёулангаас нь дахиад тодруулъя. Тэгвэл энэ үр дүнг, үрж дууссан мөнгийг уялдааг хаана хангах ёстой юм бол оо? Хэний хийх ёстой ажил юм бол оо? Хөтөлбөр дээрээ тавьсан үр дүндээ хүрч байгаад мөнгөө бүрэн зарцуулж болно, дутуу зарцуулж болно. Гэхдээ хүрсэн үр дүнгээр нь хэмждэг болоод явахгүй бол болохгүй ээ гээд 2 жил ярьж байгаа. Энийг хэзээ хийх вэ гэдэг асуулт.

Хоёрдугаарт нь Хэрэг эрхлэх Б.Энхбаяр сайдаас дахиад асууя. Би хөрөнгийн өгөөжийг л асуугаад байгаа шүү дээ. Төрийн өмчийн бодлого зохицуулах газар энийг жил болгон гаргадаггүй юм уу? Бид нар ингээд л хэдэнд хэд байдаг юм, хэд байдаггүй юм, Монгол Улсад ард түмэнд өгөөж байгаа үгүй гэдгийг ингээд мэдэхгүй л яваад ирсэн болж таарч байгаа юу? Би энд 3 дахь, 4 дэх, 5 дахийн чуулган дээр би дахиад адилхан асуулт асууна шүү сайд аа.

Да.Цогтбаатар: Энхбаяр сайдын микрофоныг өгье.

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Б.Энхбаяр: Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн асуудлыг бид 1996 онд батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хуулиар зохицуулж байгаа. 30 жил 1 хуулиар. Энэ хуульд 24 удаа тийм хууль дагасан засвар орж байснаас өөр засвар хийгдэж байгаагүй. Энэ хууль нь ямар хууль вэ гэхээр төрийн өмчийг хувьчлах тухай хууль. Төрийн өмчийн компаниудыг байгуулахаас эхлүүлээд тэнд татан олон нийтийн хяналт, төрийн хяналтыг хийхээс эхлүүлээд энэ дээр 30 жилийн өмнө баталсан бид эзэнгүй юм шиг ийм хуультай 30 жил болчихсон юм. Одоо бид нар яг энэ долоо хоногт Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн ил тод байдал нээлттэй байдлыг хангах хуулийг 30 жилийн дараа батлагдах батлах гэж байгаа юм. Та хэрэв анзаарах юм бол энэ Улсын Их Хурлын хяналтаас гараад явчихсан. Улсын Их Хурал дээр энэ том төрийн өмчийн компаниудын бүтэц, төсөв, хөрөнгө оруулалттай холбоотой, гүйцэтгэлтэй холбоотой ямар ч хяналт байхгүй 30 жил.../минут дуусав./

Да.Цогтбаатар: 2 номер.

Б.Хулан: Түрүүн Лувсанжамц гишүүн төрийн өмчит компаниудын ашигт ажиллагаатай холбоотой асуултад нэмж тодруулж хариулъя. Төрийн өмчийн бодлого зохицуулалтаас бас дараа нь нэмээд хэлж болох байх.

2025 оны санхүүгийн тайланг Сангийн яам 02 сарын 10-ны дотор 108 төрийн өмчит компанийн санхүүгийн тайлан дээр бас шинжилгээ хийж үзсэн байгаа. Гишүүн “return on equity”, “return on asset” гээд өөрийн хөрөнгийн өгөөжийн талаар тоо асууж байх шиг байна. Тэгэхээр бидний тооцооллоор бол нийт “return on equity” буюу өөрийн хөрөнгийн өгөөж нь дунджаар 9.8 хувь байсан. Энэ дээрээс уул уурхай нь 13.1 байсан. Тэгээд ингээд хасаад томоохон уул уурхайн компаниудаа хасаад үзэхээр өөрийн хөрөнгийн өгөөж бол бас их доогуур, олон улсын дунджаас доогуур гэж гарч байгаа.

Хөрөнгийн өгөөж буюу “return on asset” нь тухайн 108 аж ахуйн нэгж дээр 5.7 хувь байсан. Үүнээс мөн уул уурхай, тээвэр гэдэг 2 салбарыг хасахаар мөн бас их бага үзүүлэлттэй гарч байгаа. Хэрэг эрхлэхийн сайдын хэлсэнчлэн бас энэ чиг.../минут дуусав./

Да.Цогтбаатар: Нэмэх үү? 2 номерын микрофоныг нэмье.

Б.Хулан: Энхбаяр сайдын хэлсэн дээр бас нэмээд хэлэхэд энэ чиглэлээр бол өнгөрсөн 2001-2022 оны хооронд нийтдээ Улсын Их Хурлаас 5 удаагийн тогтоол, шийдвэр, үндсэн чиглэл батлагдаж байсан. Эдгээрт давхардсан тоогоор 115 төрийн өмчит компанийг хувьчлах, хувьцааг нь биржээр арилжаалах гэх мэтчилэн чиглэлүүд гарч байсан боловч хэрэгжилт нь 21 хувьтай буюу 2 л компани Хөрөнгийн бирж, Төрийн банк гэдэг хоёр л компани хэсэгчлэн IPO хийсэн ийм үр дүнтэй байгаа юм. Тэгэхээр энэ дээр бас санал, санаачилга боловсруулаад сайдын хэлсэнчлэн бас наадмаас өмнө ямар ч байсан ажил эхлүүлэхээр Засгийн газрын бас ажиллаж байна. Дараагийн асуултад нь Эдийн засгийн яамны дараа нэмээд хариулъя.

Да.Цогтбаатар: 3 номер.

И.Батхүү: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү. Тантай санал нэг байна. Төсвийн

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

санхүүжилтийн мөнгөн хөрөнгийн гүйцэтгэл биш гарсан үр дүн бол хамгийн чухал бодитой үр дүн гүйцэтгэлд чиглэсэн төлөвлөлтийг нэвтрүүлж эхлээд ажиллаж байгаа. Сая 2026-2030 оны таван жилийн хөгжлийн үндсэн чиглэлийг Улсын Их Хурлаар соёрхон батлуулсан.

Энэ үндсэн чиглэл нь бол 364 үр дүнтэй, 516 шалгуур үзүүлэлттэй байгаа. Эдгээр үр дүнг цаашид жил бүрийн улсын төсөвт төсвийн төлөвлөлттэй уялдуулж суулгаж явах ёстой. Эдийн засаг, хөгжлийн яамны зүгээс Улсын Их Хурлын 113 дугаар тогтоолоор батлагдсан энэ таван жилийн үндсэн чиглэлийн шалгуур үр дүн, үзүүлэлтийг яаж тусгах вэ гэдэг дээр аргачлал боловсруулаад ажиллаж байгаа. Энэ намрын чуулганаар Улсын Их Хуралд өргөн барина гэж тооцоолж ажиллаж байна. Бас таван жилийн үндсэн чиглэлийг боловсруулахад нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшлийг харьцуулах шаардлагатай шалгуур үзүүлэлт.../минут дуусав./

Да.Цогтбаатар: 3 номер нэмж хариулъя.

И.Батхүү: Зарим шалгуур үзүүлэлтүүдийг цаг хугацааны болон тэр датаг нь гаргах байгууллагуудын чадавхын асуудал, бэлэн байдлын асуудлаас болоод тооцох боломжгүй байсан. Тухайн үедээ бол таван жилийн үндсэн чиглэлд тооцох үзүүлэлт гэдэг байдлаар тусгаад тухайн жил бүр гаргах ахиц, дэвшлийг нь бол зорилтот үзүүлэлт болгож тусгасан байгаа.

Эдийн засаг, хөгжлийн яамнаас эдгээр тооцох үзүүлэлтүүдийг бэлэн болгох тал дээр маш их анхаарч ажиллаж байгаа. Үндэсний статистикийн хороо бас энэ дээр маш сайн дэмжиж ажиллаж байгаа. Бусад байгууллагуудтай бас хамтарч ажиллаж байгаа.

Да.Цогтбаатар: Лувсанжамц гишүүний микрофоныг өгье.

Г.Лувсанжамц: Сангийн дэд сайд Хулан, тэгээд Эдийн засаг, хөгжлийн яаманд баярлалаа. Ингээд тодорхой хариулт нэхэж байгаа шүү дээ? Тодорхой хариулт хэрэгтэй. Нэмээд тодруулчихъя. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас энд хүн байгаа юу? Сая уул уурхай. Сайн байна уу та? Сая уул уурхай дээр бол 13.1 хувь гээд бусад дээр бол Сангийн яаман дээр бол судалгаа хийгээгүй, эсвэл тоо нь байхгүй байсан уу үгүй юу тэндээс авъя. Тэгээд орон нутгийн өмчтүүдийг мэдмээр байгаа юм.

Орон нутгийн өмчит дээр байгаа хөрөнгийн өгөөжийг мэдэх хэрэгтэй байна. Нийтдээ төрийн өмчийн 100 гаруй компани 60 мянга гаруй хүн ажиллаж байгаа. Орон нутгийн өмчийн 4, 500. Өнгөрсөн жилийн байдлаар бол 450 гэсэн тоо гарсан. Тэнд 20 мянган хүн ажиллаж байгаа. Энэ 80 мянган хүмүүс төрийн хамааралтайгаар ажил хөдөлмөр эрхлээд байдаг. Амьдрал, аж ахуй, орлого нь сайжирч байна уу, эсвэл Монгол Улсын нийгэм эдийн засагт үр өгөөж өгч байна уу гэдгийг л энэ хөрөнгийн өгөөжөөр л хэмжих нь хамгийн зөв шалгуур үзүүлэлт гэж бодоод байгаа юм. Энэ дээр Төрийн өмчийн бодлого, зохицуулах газраас хариулт авъя.

Да.Цогтбаатар: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргыг бас дуудсан. Ирээгүй байх шиг байна. Оронд нь ирсэн хүн урагшаа микрофон дээр суучхаарай. Тэр болтол энэ хариулж байгаа улсууд аль болох ийм онолын хариулт хэлмээргүй байна. Бид нар ингэж ажиллах ёстой. Эсвэл ингэдэг байхгүй юу энэ

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

тэр гээд нөгөө энэ гишүүддээ эсвэл асуулт асууж байгаа хэн нэгэнд онолын хичээлийн юм хэрэггүй. Өнгөрсөн хугацаанд та Монгол Улсын яам хариулж, яам хариуцаж хариулж байгаа учраас яг тодорхой асуултад нь товч хариулбал сайн байна. Тэгэхгүй хичээл заалгах гэж суугаагүй гэдгийг бас сайн ойлгоорой.

1 номер дээр суучихъя та. 1 номерын микрофон.

В.Дарханбаатар: Сайн байцгаана уу? Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас жил бүр

Да.Цогтбаатар: Албан тушаал нэрээ хэлээрэй та.

В.Дарханбаатар: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Удирдлага, төлөөллийн албаны дарга Дарханбаатар.

Да.Цогтбаатар: 1 минутаар яваад байх шиг байна. Эхнээс нь өгөөрэй.

В.Дарханбаатар: Нийт төрийн өмчтэй 101 компанийн хүрээнд бол жил болгон эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг бол гаргадаг. Энд бол мөн хөрөнгийн өгөөжийг бол жил болгон тооцдог байгаа. Энэ жилийн 25 оны жилийн эцсийн байдлаар бид тооцсон үндсэндээ хөрөнгийн өгөөж нь бол 2.89-тэй байгаа. Бид энэ жилийнхээ товхимлыг мөн хэвлэлтэд өгөөд байж байна. Жил болгон орон нутаг бол мөн тусдаа 383 аж ахуйн нэгж хамрагдаж байгаа. Эндээс орон нутгийн үйлдвэрийн өмчит газар 319, орон нутгийн өмчит компани, хувьцаат компани 15, орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай хувьцаат компани 49 гээд 383 компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд бол нэгтгэгдээд гарч байгаа. Үүгээр бол хөрөнгийн өгөөж нь бол 2.9 хувьтай байгаа. Орон нутаг нь. Төрийнх нь мөн 2.9-тэй л байгаа.

Да.Цогтбаатар: Гүйцээж хариулах юм байгаа юу? Уг нь эндээс нөгөө ажилчдын чинь нийгмийн баталгаа хангагдаад амь амьдрал нь сайжраад байж чадаад байна уу гээд асуугаад байсан. Хариулах уу? 1 номер чинь хэн билээ? Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Лувсанжамц гишүүний хоёр дахь асуултад хариулах уу? 1 номерын микрофон.

В.Дарханбаатар: Энэ дээр бол ажилчдын асуудал гээд, нийгмийн асуудал шийдвэрлэх чиглэлээр бол Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар бол холбогдох төрийн өмчийн компаниуддаа бол чиглэл өгч ажиллаж байгаа. Мөн нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд үйлдвэрчний эвлэл болон бусад байгууллагуудтай хамтын ажиллагаатай ажилладаг. Энэ хүрээндээ бол мөн бас төрийн өмчит компаниудын үр ашгийг дээшлүүлэх, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр бол тодорхой ажлуудыг зохион байгуулж явуулж байгаа.

Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хувьд бол бид зөвлөмж, чиглэл хүргүүлэхээс өөр ямар нэгэн хууль, эрх зүйн хувьд бол оролцох боломж байхгүй байгаа. Ялангуяа энэ хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлж байгаа 10 гаруй байгууллагууд өөрсдөө ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэгч нь шийдвэр гаргаж байгаа учраас тэр компаниудын аж ахуйн нэгжүүдийн ажилчдын нийгмийн асуудал янз бүрийн зүйлд бол бид оролцох боломжгүй. Зөвхөн зөвлөмж өгөөд байж.../минут дуусав./

Да.Цогтбаатар: Баярлалаа. Түвшин гишүүний микрофоныг өгье.

Б.Түвшин: Баярлалаа. Төсвийн нэгдсэн гүйцэтгэл хэлэлцэж байна. Тэгээд энэ тогтоолын төсөлд оруулж болох уу? Энэ Хууль зүйн яамныхнаас бас асуучихъя. Нэгдүгээрт энэ хуулийн хугацаа хэлэлцэх дэг, хэлэлцэх асуудлыг энэ ижил төстэй байдлаар нь ангилж хэлэлцэхгүй бол нэгдсэн төсвийг хэлэлцэх дээр, гүйцэтгэлийг хэлэлцэх дээр ерөөсөө ойлгож байгаа ч юм байхгүй, асуулт, хариултууд их олон тархай бутархай яваад байна л даа.

Тийм учраас нэгдүгээрт энэ төрийн өмчит компаниудын тайлан, нэгтгэсэн тайлан гэсэн байдлаар ангилбал энэ хүмүүст хариулахад ч гэсэн амар, анализ судалгаанууд хийхэд ч гэсэн амар, асуулт, хариулт хүмүүсийн, Их Хурлын гишүүдийн анхаарал төвлөрч энэ төрийн өмчит компаниудын талаар яривал их зүгээр харагдаж байна. Тэгээд үүний дараа бол төсөвт байгууллагуудынхаа тайлангуудыг нэгтгээд тэгээд төсөвт байгууллагуудаа яриад тэгээд эцэст нь бол харин нэгтгэсэн тайлангуудаа хэлэлцдэг ийм байдлаар хийх боломжтой юу? Энийг хууль санаачлах уу эс үгүй бол энэ тогтоолын төсөлд оруулж болох уу гэдэг нэг ийм асуулт.

Хоёрдугаарт, энэ суурь тэнцлийн шаардлага дотоодын нийт бүтээгдэхүүний 1.2 хувьд хүрээд миний харж байгаагаар бол Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг зөрччихлөө. Нэгдүгээрт шалтгаан нь юу вэ? Хоёрдугаарт энд хариуцлага тооцох уу? Хэний буруу вэ гэдэг ийм асуулт.

Гуравдугаарт энэ урсгал зардал ярьсаар байгаад сүүлдээ энэ урсгал зардлын түвшин гээд ингээд хожиж авч байх шиг л байна. Тэгэхдээ дахиад л ярихаас өөр арга байхгүй. 2025 онд 77.4 хувь нь, нийт орлогынхоо 77.4 хувийг бид нар урсгал зардалд зарцуулж байна. Тодотгосны дараах байдлаар. Хэрвээ тодотгоогүй байсан бол энэ хэд болох вэ? Энэ чинь юу гэсэн үг юм бэ гэхлээрээ бид нар Оюу толгойгоос олж байгаа бүх мөнгө, Тавантолгойгоос олж байгаа бүх мөнгө, Эрдэнэтээс олж байгаа, уул уурхайгаас олж байгаа бүх мөнгө, бүх татваруудаа урсгал зардалдаа л зарцуулж байна гэсэн үг. Энэ урсгал зардал чинь 77 хувь буюу тодотголын дараах орж байгаа чинь хэрвээ тодотголын өмнөхөөс тооцвол 90 хувь гарах байх. Тэгэхлээр энэ тоог ер нь хэд байна, энийг ер нь цаашдаа яаж бууруулах вэ гэдгийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс эхлээд асууя гэж бодож байна.

Яагаад гэхлээр энэ цалин, тэтгэвэр, халамж бол ер нь миний тооцоогоор бол 50-аас дээш хувь гараад явчихлаа. Бид нар олсон бүх мөнгөө цалин, тэтгэвэртээ хийж байна. Энэ цалинг бууруулах бодлого уг нь бол цалингийнхаа ангиллыг зөв хийх юм байгаа юм. Ядаж унаа, хоолны хөнгөлөлтүүдийг нь шууд зардал юм гэдгийг хүлээн зөвшөөрч түүнээс нь нийгмийн даатгал төлөхөө болих ёстой юм байгаа юм. Цалингуудаа анализ хийж задрах ёстой юм байгаа юм. Тэгээд энэ асуудлууд ерөөсөө явахгүй байна. Цаашдаа бид нар олсон бүх мөнгөө яг урсгал зардалдаа хийгээд цалин, тэтгэвэр, халамждаа суулгачхаад юу ч хийж чадахгүй төсвийн тодотгол оруулж ирэхээрээ бүх хөрөнгийн зардлуудаа бууруулаад оруулаад ирдэг энэ байдал бол эдийн засгийн хөгжил авчрахгүй. Энэ дээр бол Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд нөгөө тодорхой хариулт өгөөдхөөч.

Да.Цогтбаатар: Түвшин гишүүнд баярлалаа. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Дэлгэрсайхан дарга. Тэр 9 микрофоны аль нэгэн дээр нь суух нь дээ.

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Өмнөх асуултад нь хариулж байгаа юу Сангийн яам Түвшин гишүүний асуултад? Хуулиас хэн хариулах вэ? 6 номер дээр сууж байгаа хүн нэр албан тушаалаа хэлээд яриад байгаарай манайхан. 6 номерын микрофоныг өгье.

Б.Батбямба: Түвшин гишүүний асуултад хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн яам Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батбямба байна. Засгийн газар дээр энэ Улсын Их Хурлын Улсын Их Хурал дээр тайлан хэлэлцүүлж байгаатай холбоотой асуудлаараа мэдээллүүд, холбогдох шийдвэрийн төслөө хүргүүлчихсэн байгаа. Ингээд Их Хурлын дэгийн тухай хуулиараа харин энэ тогтоолд өөрчлөлт оруулахтай холбоотой асуудлаа хэлэлцээд явах байх. Засгийн газрын зүгээс холбогдолтой мэдээллүүдээ, холбогдох шийдвэрүүдээ бол гаргаад хүргүүлчихсэн. Тайлан, мэдээллүүдээ эцэслээд гаргаад өгчихсөн байгаа.

Да.Цогтбаатар: Одоо бол та тайлан өгчихсөн гэхгүйгээр шууд хариулах хэрэгтэй байх. Яг яах ёстой гэдгээ ... юмаа та наанаа ярих юм.

Б.Батбямба: Их Хурлын тогтоолын төсөл дээр бол манайх өөрчлөлт оруулах Засгийн газар Хууль зүй, дотоод хэргийн яам энэ дээр бол ямар нэгэн шийдвэр гаргах боломжгүй болчихсон байна гэсэн. Их Хурлын мэдэх асуудал болчихсон гэсэн үг.

Да.Цогтбаатар: 8 номер Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Дэлгэрсайхан дарга.

Ж.Дэлгэрсайхан: Түвшин гишүүний асуултад хариулъя. Ер нь урсгал зардлын хэмжээ дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх болон төсвийн нийт нэгдсэн төсвийн нийт гүйцэтгэл төлөвлөлтөд эзлэх хувийн жин өссөөр байгааг бол бид байнга дүгнэлтүүдээ хэлж байгаа. Энэнтэй холбоотойгоор манай 2026 оны төсөв батлах дээр өгсөн дүгнэлтдээ бид нар төсвийн төсөлд өгсөн дүгнэлтдээ урсгал зардлын өсөлт жил ирэх тусам нэмэгдсээр байгаа нь улсын төсвийн бодлогын орон зайг хумьж байна гэсэн ийм дүгнэлт хийсэн.

Энэ бодлогын орон зайг хумьж байна гэдэг нь таныг асуултын хоёр дахь хэсэгтэй холбоотой буюу хөрөнгийн зардал гэдэг зүйлийг бид төлөвлөж хэрэгжүүлж байгаа байдал нь хэмжээ нь багасаж байгаагаас гадна хөрөнгийн зардлыг буюу хөрөнгө төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг бууруулаад байгаа ийм нөхцөл байдлыг үүсгэж байгаа юм.

Эцэстээ энэ урсгал зардал нийт хөрөнгийн зардлаа шахсанаас болоод төсвийн хөрөнгө оруулалтыг шахаж төсвийн хөрөнгө оруулалтын зардал нь өөрөө төсвийн бод .../минут дуусав./

Да.Цогтбаатар: 8 номерын микрофоныг нэмж өгье.

Ж.Дэлгэрсайхан: Баярлалаа. Төсвийн хөрөнгө оруулалтын зардал нь өөрөө төсвийн бодлогын тохиргооны хэрэгсэл болж хувираад байгаа юм. Тэгээд таны хэлсэн төсвийг тодотгох, төсвийн тодотгол хийх, төсвийн зарлагыг бууруулах орон зай бол зөвхөн хөрөнгийн зардал дээр гараад хөрөнгө оруулалтын зардал гэдэг зүйл бол төлөвлөлт нь хэлбэрийн төдий болоод хэрэгжилтийн түвшин маш доогуур түвшинд гарч ирж байгаа.

Энэний эсрэг бидний өгч байгаа зөвлөмж бол ерөнхийдөө Монгол Улсын төсвийн зарлагын тэлэлтийг дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийн жинг нь бууруулах, мөчлөг сөрсөн бодлого явуулах, төсвийн мөчлөг сөрсөн бодлого явуулаагүйгээс болоод хөрөнгийн зардал болон төсвийн эрсдэлүүд дээр асуудал үүсэж байгаа гэж үзэж байгаа.

Хамгийн гол явуулах зорилготой зүйл нь бол макро эдийн засгийн бодлого дээрээ илүү анхаарахгүй бол болохгүй юм байна. Тэгэхгүй бол макро эдийн засгийн бодлого дээрээ илүү анхаарахгүй бол төсвийн бодлого мөнгөний бодлого дээрээ ч гэсэн харилцан уялдаатай нөлөөлөл бий болж байна гэсэн ийм дүгнэлт хийж байгаа. Тэгэхээр төсвийн урсгал зардлын өсөлтийн шалтгаан болсон.

Да.Цогтбаатар: Уг нь Зарлагын хяналтын дэд хорооны хурал дээр 133 их наяд төгрөгийн асуудал яригдаж байгаа. Хэрэг эрхлэхийн сайд орж ирсэн. Сангийн сайд орж ирсэн. Бас яг Монгол Улсаа төлөөлөөд өнөөдөр бас онцгой ажилтай байгаа учраас өөрөө учир байдлаа хэлээд чөлөөгөө аваад явсан. Тэгээд Номтойбаяр сайд уг нь холбогдож байсан ирмээр юм ярьсан. Аубакир сайд бас учир шалтгаанаа хэлээд гарсан. Бусад сайд нар нь уг нь болж өгвөл ирээд жаргал, зовлонгоо хэдүүлээ ярихгүй бол нарийн мэргэжлийн хуулийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нь тайлангаа өгчихсөн шүү дээ гэдэг байдлаар суугаад байж болохгүй байна. Эсвэл та тодорхой хариулаад, эсвэл сайдыгаа авчирч хариулуулахгүй бол энэ танай яаман дээр явагдаж байгаа хурал биш гэдгийг сайн ойлгох хэрэгтэй байна. Яаман дээрээ ч гэсэн иймэрхүү байдлаар ажилладаг байлгүй гэж найдъя.

Түвшин гишүүний микрофоныг өгье.

Б.Түвшин: Уг нь тодорхой асуулт асуугаад байна л даа. Энэ төсвийн нэгдсэн гүйцэтгэлийг төрийн өмчит компаниудыг тусад нь хэлэлцээд, төсөвт байгууллагуудын тайлангуудыг тусад нь хэлэлцээд, тэгээд нэгтгэснээр хэлэлцдэг болох боломжтой юу? Нэгдүгээрт тогтоолын төсөлд өөрчлөлт оруулах боломжтой юу? Боломжгүй бол энэ хууль санаачлах уу гээд би яг мэргэжлийн чиглэлийн асуулт асуугаад байна л даа.

Хоёр дахь асуул. Сая энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг уншсан. Уг нь ер нь бол 100 хувь санал нийлж байгаа. Энэ урсгал зардлын тухай санаа зовоод л байгаа. Гэхдээ яг одоо урсгал зардлыг бууруулахдаа тодорхой бодлогын чиглэлүүд бас өгч байна уу? Та хэдийн өгсөн зөвлөлүүдийг энд авч хэрэгжүүлэхгүй байгаа болохлоор яах ёстой вэ? Угаасаа л хэдүүлээ энэ урсгал зардлын талаар л яриад байгаа.

Гуравдугаарт суурь тэнцлийн шаардлага дотоодын нийт бүтээгдэхүүний 1.2 хувьд хүрсэн үүний шалтгаан, хариуцах эзэн хэн бэ гэж асуусан шүү дээ. Ийм гуравхан л асуулт асуусан. Дахиад тодруулаад өг дөө.

Да.Цогтбаатар: Энхбаяр сайдын микрофоныг өгье нэгдүгээр асуултад хариулъя гэж байна.

Б.Энхбаяр: Түвшин гишүүний асуултад хариулъя. Үнэхээр төрийн өмчийн компанийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, бизнес төлөвлөгөө ингээд гүйцэтгэл

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

гэсэн энэ 3 асуудал бол яг ард түмний төлөөллийн байгууллага Улсын Их Хурал дээр бол орж ирдэггүй. Аудитын энэ төсвийн гүйцэтгэл дотор өр төлбөрийн асуудал орж ирж байгаа. Тэгэхдээ их ерөнхий байдлаар орж ирж байгаа.

Тийм учраас энэ Төрийн өмчийн компанийн ил тод байдлын тухай хуульд энэ гүйцэтгэлийн төлөвлөгөөг Улсын Их Хуралд энэ төсвийн гүйцэтгэлээс тусад нь хэлэлцэж, танилцдаг ийм хууль одоо бид нар баталж байгаа юм. Анх удаа сүүлийн би сая хэлж байна шүү дээ энэ 30 жилд энэ төрийн өмчийн компани чинь эзэнгүй, ард түмнийхээ хяналтаас гараад явчихсан гэдэг чинь Улсын Их Хурлын хяналтаас гараад явчихсан гэсэн үг байхгүй юу. Юу ч орж ирдэггүй. Тийм учраас одоо төрийн.../минут дуусав./

Да.Цогтбаатар: Нэмэлтээр Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Одоо бол төрийн өмчийн компаниудыг бол Засгийн газар түүгээрээ байгуулах, татан буулгах эрх нь байгаа. Орон нутгийн өмчийн компаниудыг болохоор иргэдийн Төлөөлөгчдийн Хурлууд өөрсдөө түүгээрээ байгуулах татан буулгах эрх нь байгаа учраас ингээд зах хязгааргүй яваад хяналтаа алдчихаад байгаа юм.

Үндсэн хуульд зааснаар иргэдийн хурлуудын тэр байгуулж байгаа шийдвэрүүдийг төв Засгийн газар болон Улсын Их Хурал хянаж хүчингүй болгох ийм эрх байхгүй болчихсон. 2009 онд Цэцийн дүгнэлт гараад иргэдийн хурлын шийдвэрийг Улсын Их Хурал хүчингүй болгодог эрхийг нь Үндсэн хууль зөрчсөн гээд хүчингүй болгочихсон юм. Тийм учраас энэ бүхэлдээ ингээд Улсын Их Хурлын хяналтаас ч гараад явчихсан гэсэн үг байхгүй юу. Тийм учраас бид нар энэ Төрийн өмчийн компанийн хууль дээр Улсын Их Хурлын зөвшөөрлийг авч байж төрийн өмчийн компани байгуулах асуудлыг шийдвэрлэдэг бүүр заалт оруулж байгаа шүү дээ. Энэ бол бас нэлээн том ийм реформ, шинэтгэл болох байх гэсэн бид бол ийм хүлээлттэй байгаа. Тэгээд энэ манай.../минут дуусав./

Да.Цогтбаатар: 8 номер хариулъя микрофон. Асчихсан байна.

Ж.Дэлгэрсайхан: Түвшин гишүүний асуултад хариулъя. Ер нь бидний урсгал зардал болон төсвийн зарлагатай холбоотой гол дүгнэлтүүдийг танд дахиад дурдъя. Бид нарын хувьд бол энэ үр дүнд суурилсан төсөв рүү орохгүй бол зардлуудыг зүгээр хуульчлан болон санаачлан нэмдэг, зардлууд энэ Сангийн яамны хэлж байгаагаар бол 100 хэдэн хуулиар бол төсвийн урсгал зардлыг нэмэх нөхцөлийг бүрдүүлсэн гэж ярьдаг. Тэгэхээр энэ урьд үр дүнд суурилсан тогтолцоо руу шилжээгүй цагт бид нар үр дүнд суурилсан тогтолцоогоороо үнэлж, үр ашиггүй зардлуудыг танах энэ боломж байхгүй юм байна гэсэн дүгнэлтүүдийг бид хийдэг, хийж байсан.

Дараагийнх нь урсгал зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг тодорхой хэмжээгээр тодорхой түвшинд барих нь бол бас урсгал зардлыг үр ашиггүйгээр, янз бүрийн шалтгаантайгаар нэмэх энэ орон зайг хаах юм байна гэж дүгнэлтүүд өгч байсан. Дараа нь нийгмийн халамж болон.../минут дуусав./

Да.Цогтбаатар: 8 минутын микрофоныг нэмж өгье.

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Ж.Дэлгэрсайхан: Нийгмийн халамж болон төрийн албан хаагчдын цалин хөлстэй холбоотой өсөлтүүд урсгал зардал дээр томоохон байр суурь эзэлж байгаа энэ байдал дээр бол нийгмийн халамж болон тэр цалин хөлсний бодлогын шинэчлэлийг бол хийх шаардлагатай гэж үзсэн. Манай дүгнэлтийг хэрэгжүүлэх гол арга замыг бид ингэж харж байгаа. Улсын Их Хурлаас төсвийн гүйцэтгэл төсвийн төсөл батлахтай холбоотойгоор Засгийн газарт тодорхой чиглэл, үүрэг даалгавар өгдөг. Энийг энд манай зөвлөлийн дүгнэлтийг хамруулж чадсан тохиолдолд эргээд Засгийн газартаа бол болон төсвийг төсвийн ерөнхийлөн захирагч нараас эргээд эдгээр дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг нэхэх ийм үндэс бүрдэнэ гэж үзэж байгаа юм.

Да.Цогтбаатар: Нэмэлт хариулт 2 номер.

Б.Хулан: Сангийн дэд сайд Хулан. Түвшин гишүүний асуултад нэмэлт тодруулга өгье.

Төсвийн тусгай шаардлагын тухайд бид нар Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-оо хангаж чадаагүй нь бол үнэн. Ингээд 2025 оны гүйцэтгэлээр 1 их наяд 113 тэрбум төгрөгийн ашигтай буюу энэ нь дотоодын нийт бүтээгдэхүүний 1.2 хувь, хуулиар заасан 2 хувьдаа бол хүрээгүй нь үнэн. Та шалтгаануудыг бас асууж байх шиг байна. Тэгэхээр энэ дээр бас хэд хэдэн зүйлийг хэлэх боломжтой байна.

Нэгдүгээрт бол бид нар бол орлого талдаа төлөвлөснөөс бол орлого төсвийн орлого бол бага байсан. Энэ нь нэгдүгээрт бол бидний экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрсний үнэтэй холбоотой. Нүүрсний үнийг бид нар 2025 оны төсвийн төсөөлөлдөө дундаж үнэ 70 байхаар авсан боловчиг гүйцэтгэлээр бол 64 орчим байна.

Төсөвт нөлөөтэй орлогуудыг жагсаагаад аваад үзэхээр нэгдүгээрт бол нүүрсний үнэ, хоёрдугаарт биет хэмжээ, 3 дугаарт зэс гээд ингээд явдаг. Биет хэмжээний тухайд бол бид 85 сая тонн бай.../минут дуусав./

Да.Цогтбаатар: 2 номерын микрофоныг нэмж өгье.

Б.Хулан: 85 сая тонн байхаар төсөвлөсөн үнэ унасантай холбоотой бас экспортыг эрчимжүүлэх арга хэмжээ авсны үндсэн дээр бас 90 сая тонныг экспортолж ингэж чадсан байна.

Нөгөө талаасаа бол бас энэ гадаад, дотоод нөхцөл байдалтай холбоотой, валютын ханш, гадаад валютын албан нөөцийг хамгаалах, хэрэглээний зээлийг хумих, инфляцыг хумих гээд энэ зөвхөн Сангийн яам гэлтгүй санхүүгийн тогтвортой байдал дээр хэлэлцэгддэг энэ бодлогын арга хэмжээг бол өнгөрсөн оны хавраас авч хэрэгжүүлсэн. Үүнтэй холбоотой мөнгөний чанга бодлого төв банкнаас хэрэгжүүлж, мөн хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааг чангатгах гэх мэт эдгээр бодлогын арга хэмжээ авсны үндсэн дээр хэрэглээний зээл буюу энэ импортоор орж ирж байгаа автомашины импорт бол бас тодорхой хэмжээгээр буурсан.

Энэний давуу тал нь бол гадаад валютын албан нөөцтэй эргээр нөлөөлсөн. Ханшийг бас тодорхой хэмжээнд тогтвортой барихад нөлөөлсөн. Нөгөө талдаа

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

бол яг төсвийн орлого тал дээрээ гаалийн орлогыг бас бууруулсан гэж ингэж үзэж байгаа. Өөрөөр хэлэх юм бол импортоор бараа, бүтээгдэхүүн орж ирэхгүй байхад бид түүн дээр гаалийн татвар.../минут дуусав./

Да.Цогтбаатар: 5 номер хариулъя гэсэн үү? Түвшин гишүүний микрофоныг өгье.

Б.Түвшин: Энэ урсгал зардал дээр бол ер нь ийм л асуудал байгаад байгаа юм л даа. Төсвийн хүрээний мэдэгдлээ дахин тодотгодог. Тэгээд энэ чинь уг нь 1-3 жилийн баримжаа гаргадаг. Тэгээд ярих болгондоо мөчлөгийн асуудал ярьдаг. Мөчлөггүй төсвийн хүрээний мэдэгдлээ гаргачхаач ээ. Тэгээд ямар мөчлөг болоод байгаа юм тэрийг чинь тааруулаад гаргая.

Хоёрдугаарт Төсвийн хүрээний мэдэгдлийн 9 хүрээний 9 үзүүлэлтийг 12-16 гаргаж, ялангуяа нийгмийн шинж чанартай зардлуудыг дотоодын нийт бүтээгдэхүүн дээр тогтвортой барьж, тэрнээс давуулахгүй байх гэсэн ийм шаардлага тавьж байгаа. Энэ дээр бас Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бас хамтарч ажиллаарай гэж ингэж хүсэх байна. Энэ төсвийн хүрээний мэдэгдэл 3 жилийнхээ баримжааг авахгүй бол болохгүй.

Энэ орлогын төлөвлөлт дээр жил болгон төсөв хэлэлцэхэд Их Хурлын гишүүд орлого чинь их байна гэдэг. Засгийн газар орлогоо л ихэсгэх гэдэг. Ингээд дараа нь тодотгол хийдэг. Үр дүнд нь хөрөнгийн зардал буурч, урсгал зардал гараад явдаг ийм л үр дүнд явсан. Одоо яг л саяын асуудал яригдаж байна. Тийм учраас дараа нь орлогоо.../минут дуусав./

Да.Цогтбаатар: 2 номер хариулъя. Сангийн дэд сайд.

Б.Хулан: Орлогоос гадна бас нэг нөлөөлөөд байгаа зүйл нь энэ Төсвийн тухай хуулийн 52.7.Орон нутгийн төсвийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл тухайн жилийн төсвийн хуульд нийцүүлэн алдагдалгүй төлүүлж баталж хэрэгжүүлнэ. гэсэн заалт.

57.3 буюу орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжигдвэл эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна гээд энэ 2 заалттай бас их холбоотой байгаа юм.

Тэгээд ингээд үзэхээр 2025 он дээр бид нар орон нутгийн төсөв дээр бол 500-аад тэрбум төгрөгийн бас алдагдалтай гүйцэтгэлээр гарсан. Энэ нь бол урьд онд санхүүжүүлээгүй төслөө дараа оны алдагдал руу ингэж чирч оруулаад байгаа ийм асуудлаас бас давхар үүсэж байгаа гэдгийг хэлье.

2025 оны тухайд суурь орлого, зарлагыг бол 6.9 их наядаар орон нутагт төлөвлөөд ийм тэнцэл нь тэг байхаар оруулсан боловчиг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дээр бол орлогыг 1.5 их наядаар, зарлагыг 3.8 их наядаар баталж, нийтдээ бол 2.2 их наядын ийм алдагдалтай байхаар бас.../минут дуусав./

Да.Цогтбаатар: Нэмж хариулах уу? Сайхан ярьчихмаар л байна л даа. Түвшин гишүүний микрофоныг өгье.

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Б.Түвшин: Энэ орон нутгийн төсвийн асуудал дээр бас яг эрх зүйн асуудлыг ярихгүй бол орон нутагт чинь нэгдүгээрт хөрөнгө оруулалт хийх эрхтэй байх ёстой. Тэгэхдээ хэдий хэмжээний хүнд тэгээд тэр хөрөнгө оруулалт хийх тэр алдагдлаа нөхөх боломж нь өөрт нь бас эдийн засгийн хувьд байх ёстой. Тэгээд энэ эрх зүйн зохицуулалтыг хийж өгөхгүй бол нэг бол 100 хувь хаачих гээд байна. Үгүй бол одоогийнх шиг ингээд улсын төсөвтөө дарамт болох хэмжээний алдагдал батлаад ингээд цаашаа энэ чинь улсынхаа эдийн засгийг ч гэсэн хүнд байдалд оруулах гэж байгаа. Энэ дээр эрх зүйн ямар бодлогын арга хэмжээ авахаар төлөвлөж байгаа вэ? Ер нь цаашдаа энийг яаж зохицуулъя гэж бодож байгаа вэ? Саяын тэр тоо нааш нь цааш нь болгоод ингээд энэ удаагийн 25 оны гүйцэтгэлд нөлөөлж байна гэдэг бол зүгээр хэлбэр тал шүү дээ. Цаашдаа бид нар энэ орон нутгийн төсвийг, ялангуяа энэ улс орон нутгуудыг бол эдийн засгийн хувьд бие даалгасан, тэгэхдээ улсын төсвөө улсынхаа эдийн засгаас сүйрүүлчихдэггүй хэмжээнд байлгах тэр бодлого нь юу юм?

Да.Цогтбаатар: Зарчмын хувьд бол Түвшин гишүүний хэлээд байгааг Хууль зүйн яам ч юм уу эсвэл Засгийн газар оруулж ирэхдээ сайн анхаарч байхгүй бол одоо энд та нар 40, 50-уулаа суучихсан байна. Бүгдээрээ л өөрсдийнхөө төсвийн гүйцэтгэлийн талаар ярина гэсэн хүлээлттэйгээр хэн юу гэж асуух бол тэрэнд нь тодорхой хариулт өгчих юм сан гээд сууж байгаа байх. Тэгээд яг техникийнх нь боломж нь Сангийн яам хөөрхий минь бас нэлээн л юм яримаар байх шиг байгаа юм. Тэгээд бид нар бас яриулж чадахгүй ингээд. Одоо байгаа дэг нь, одоо байгаа зарчим нь ийм болохоор ингээд үр дүн муутай, 133 их наяд төгрөгийн гүйцэтгэлийг хэлэлцэж байгаа явц нь энэ шүү. Энийг нөгөө холбогдох газруудад нь цаашдаа анхаараад аудит ч гэсэндээ саналаа гаргаад тусад нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг нэг, тэгээд тэд нарыг болж байгаа бол харьяалж байгаа сайд нарынх нь багц багцаар хуваадаг юм уу, хуваагаад нэг нэг яриад тэгээд араас нь төсвийнхөө гүйцэтгэлийг төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр нь ярьдаг бол үр дүнд хүрнэ шүү гэдэг ийм зарчмын юм байна.

Ингээд гишүүд гишүүд асуулт асууж дууслаа.

Би 2, 3 асуулт асуучихъя. Маш товчхон хариулаад өгвөл сайн байна. Төрийн өмчит оролцоотой аж ахуйн нэгжүүдийн цалингийн мэдээллийг ил болгосон. Энэ нөгөө хэвлэлийнхэн надаас тайланг нь асуугаад байсан. Энэ чинь ингэхээр харагдаж байна уу? Төрийн аудитын байгууллагаар хийсэн тайлан. Тэгээд аудитын байгууллага руу маш их дайрч байна Энхбаяр сайд аа. Тэгээд өөрсдөө бас хөөрхөн мэдэгдэл гаргах юм Энхбаяр сайд аа. Ийм зарчим байж болдог юм уу? Мэдэгдэл зүгээр үү? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт нь болохоор цалингаа нөгөө өөрсдөө ТУЗ гээд хэдэн хүн томилж байна. Тэгээд тэр аж ахуйн нэгжүүд ерөөсөө тийм ашигтай, үр ашигтай ажиллахгүй байна. Гэсэн ч гэсэн хамаагүй 7, 800 сая төгрөгөөр нь цалин болон нэмэгдэл цалингуудыг авч байна. Тэгээд энэ нь Засгийн газрын энэ баримтлаад байгаа зарчимтай бас нийцээд байгаа юу гэдэг энэ асуултад та хариулт өгөөч.

Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Тусдаа ер нь төрийн өмчийн компанийн засаглал, ил тод байдал, энэ хэмнэлт, энэ данхайсан бүтцүүд энэ дээр явагдаж байгаа хулгай зэлгийтэй холбоотой асуудлыг ер нь бас ялангуяа сүүлийн 2 парламент бол маш

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хүчтэй яригдаж байгаа. Энэ хүрээнд ч гэсэн парламентын ил тод байдал, сонсголзуд зохион байгуулагдаж байгаа. Энэ бүхэн бол их олон зүйлийг ил болгож байгаа. Түрүүчийн парламентад би 2021 онд энэ төрийн өмчийн компаниудын асуудал ярихад ер нь 2, 3-хан л гишүүн дуугардаг байсан юм. Одоо бол ер нь бараг 90 хувь, 100 хувь энэ асуудал дээр анхаарч байгаа. Сая төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэх явцад ч гэсэн ер нь ба манай Их Хурлын гишүүд ер нь бараг энэ дээр л гол асуудал байгаа. Аудит ч гэсэн тийм дүгнэлтүүд гаргасан.

Цалингийн асуудал дээр бол 2022 онд Төрийн өмчийн хорооны даргын баталсан аргачлалын дагуу төрийн өмчийн компаниудын цалинг бол 10 саяас 35 сая төгрөгийн хооронд тогтоосон байдаг юм байна. Энэ сүүлийн 4 жил хөндөгдөөгүй, өөрчлөгдөөгүй байгаа.

Аудит маань ямар аргачлалаар гаргасныг аудит өөрөө хариулах байх гэж бодож байна. Би бол ойлгохдоо энэ урамшууллыг оруулаад гаргасан юм байна гэж ойлгож байгаа. Энэ бид нар бол 2025 оны төсвийн гүйцэтгэлийг ярьж байгаа буюу 2025 оны төсвийн жилдээ авсан цалин, урамшууллын асуудлыг би бол ярьж байгаа юм байна гэж ойлгосон. Энэ урамшуулал нь бол мөн Төрийн өмчийн хорооны даргын баталсан аргачлалаар явдаг юм байна.

Тэгэхээр бид Төрийн өмчийн компанийн ил тод байдлын хуулиар энэ асуудлыг ганцхан төрийн өмчийн компанийн цалин, урамшууллын хүрээгээр хязгаарлахгүйгээр авч үзнэ. Бид нар хараат бус гишүүдийн тоог хамгийн багадаа гуравны нэг байлгах, ер нь Засгийн газрын бодлого бол энэ хараат бус гишүүдийн тоог нэмнэ. Энэ хууль батлагдсаны дараа. Олон нийтийн хяналтыг оруулж ирнэ. Төрийн өмчийн компаниудын хамгийн багадаа 5 хувиас эхлүүлээд бид нар нээлттэй компани болох чиглэл рүү буюу олон нийтэд хяналтад оруулах энэ асуудлыг ярина.

Мэдээж дэлхийн том том уул уурхайн том акул компаниудтай энэ хэмжээний мөнгөн дүнтэй харьцуулах юм бол тэд нар бол хэдэн сая долларын цалин авдаг, урамшуулал авдаг. Тэгж байж дэлхийн зах зээл дээр өрсөлддөг ийм гигант компаниуд байгаа. Тэгэхээр бид нар бол ганцхан цалингаар бол төрийн өмчийн компанийн гүйцэтгэх удирдлагын тэр толгойг, чадварыг, багийг үнэлээд байж бас байх нь бол учир дутагдалтай байх гэж бодож байгаа.

Сайн ашигт ажиллагаа, ард түмэнд илүү үр өгөөж болох талд нь бид бас сайн хүмүүсийг татаж авч ажиллуулах боломжийг хааж болохгүй. Ойлголтын бас зөрүү ч бас энэ дотор байх шиг байна.

Жишээлбэл энэ Чингис хаан Үндэсний баялгийн нэгдэл сангийн гүйцэтгэх захирал Даваадалай захирлын цалинг 64 аравны сая төгрөг авдаг гээд ингээд зураг хөрөгтэй нь гаргаад л ингээд байна лээ. Би бол тухайлан үзсэн. Энэ хүн бол яг гар дээрээ 24 сая төгрөг авдаг юм байна лээ. Ямар нэгэн урамшуулал аваагүй байгаа томилогдсоноосоо хойш.

Жишээлбэл, эхнэр нь энд асуугаад байгаа шүү дээ чи 40 сая төгрөг надаас нуугаад хаана нуучихсан байна гээд ингээд энэ чинь гэр бүлдээ бол дотроо их сонин байдалд орчхоод байгаа хүн шүү дээ энэ чинь. Энэнээс болоод. Тийм тэгээд би бас энийг нь залруулж хэлэхгүй бол энэ чинь тийм ээ хэлэх нь зүй ёсны биз дээ энэ чинь ингээд хэвлэл мэдээллээр чи 65 сая төгрөг авдаг байна. Гэртээ болохоор

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

эхнэртээ би 24 сая төгрөг авдаг гэхээр нөгөө чи худлаа яриад байна гээд энэ чинь гэр бүлээсээ, гэрээсээ.../минут дуусав./

Да.Цогтбаатар: Би танаас зарчмын л асуудал асуусан юм. Мэдээллийг ил болголоо гээд төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд аудитын байгууллага руу ч юм уу мэдэгдэл хийгээд байдаг чинь зөв үү? Манай Нийслэлийн Засаг дарга чинь иргэдийнхээ эсрэг жагсаад л бараг л үзчихмээр хүн байвал гараад ир гээд л бараг боксын мишок барьчихсан юм шиг л юм яваад байсан. Тэр дээр танаас мэдэгдэл нь зарчмын хувьд зөв юм уу л гэж асуугаад байгаа юм. Мэдэгдэл нь.

Энхбаяр сайдын микрофоныг.

Б.Энхбаяр: Та ч намайг хөтөлж л асуугаад байна л даа. Би ч хөтөлсөн асуултад бас хариулаад байдаг ч юм биш. Мэдээж Улсын Их Хурал, Засгийн газрын энэ институцийн хоорондын харилцаа бол гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага ард түмний төлөөллийн байгууллага гэдэг утгаар бие биедээ хүндэтгэлтэй хандах ёстой.

Энэ харилцаа бол Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээ рамд байх ёстой. Ард түмний төлөөллийн байгууллагын асуултад буруу асуулт гэж байхгүй. Ард түмэн, иргэд, сонгогчид юу асуухыг хүсэж байна түүнийг Улсын Их Хурлын гишүүн, ард түмний төлөөлөгч асууж байгаа. Буруу хариулт л гэж байдаг. Тийм учраас манай энэ гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд Улсын Их Хурал дээр ялангуяа Их Хурлын гишүүдийн асуулт асуулгуудад хуулийн хүрээнд үндэслэлтэй, тооцоо судалгаатай хариулах байх гэж ингэж бодож байна. Тийм учраас та энийг бас гүйцэтгэх захирлаас тодруулаад асуучхаж болох байх гэж бодож байна.

Да.Цогтбаатар: Аудит нэмэлт хариулт. 5 номер Магнайсүрэн дарга.

С.Магнайсүрэн: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Магнайсүрэн. Бид нар Улсын Их Хурлын удирдлага болоод Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос өгсөн чиглэлийн дагуу энэ орлого нэмэгдүүлэх, зарлага бууруулах чиглэлээр тодорхой судалгаанууд хийсэн. 8 төрлийн судалгаа хийсэн. Энэ дотроос зөвхөн энэ цалин гээд ингээд асуудал нэлээн ингээд юу болоод байна. Асуудал болоод байгаа.

Бид нарын өнөөдрийн гаргаад тавьчихсан судалгаагаар бол бид нар цалин гэж ерөөсөө яриагүй. Нэг тухайн 25 онд, 25 оны санхүүгээр энэ төрийн өмчит компаниуд дотроос тухайн тэр удирдлагад нь 1 сард ноогдож байгаа цалин болон түүнтэй адилтгах орлого гээд ингэж дүгнэж өгсөн. Түүнээс нэрлэсэн цалин бол огт яриагүй. Хоёрдугаарт хүний нэр яриагүй. Энэ дотор бол хоол, унаа, тэгээд урамшуулал, шагнал энэ тэр гээд бүх юм нь орсон ийм дүн байгаа. Тэгээд энэ дүнгээр бол ийм 25 оны дүнгээр гарсан.

Да.Цогтбаатар: Дараагийн асуулт Эрчим хүчний яам. Энэ Эрчим хүчний яаман дээр чинь 288 тэрбум төгрөгийн санхүүгийн зөрчил илэрсэн гээд байгаа Эрчим хүчний яамнаас хэн байна? Төрийн нарийн байна уу? Микрофон руу ойртоод сууж байгаарай. 288 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Төрийн өмчит үйлдвэрийн газрууд нь 44 тэрбум төгрөгийн татаас олгосон. 30 төрийн өмчит аж ахуйн нэгжид нь найдваргүй, олон жилийн насжилттай 6 тэрбум төгрөгийн авлага байна. Эрчим хүчний яамны харьяа 30 төрийн өмчит компанийн 24 нь 25 онд 43.5

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллажээ. 61.5 тэрбум төгрөгийн төлбөрийг төлөлгүй үлдээснээс болж өрийн хэмжээ нэмэгджээ гэж байна. Энэ дээр та тайлбар хэлээд өгөөч. Хэдэн номер байна? 6 номер Төрийн нарийн бичгийн дарга.

Б.Ерэн-Өлзий: Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Ерэн-Өлзий. Цогтбаатар гишүүний асуултад хариулъя.

Эрчим хүчний сайдын санхүүгийн тайлангаас 288 тэрбум төгрөгийн зөрчил илэрлээ гэсэн ингээд мэдээлэл ингээд явсан. Энэ болохоор юу байна вэ гэхээр компаниуд дээрх 61 тэрбум төгрөгийн төлөгдөөгүй өр, 226 тэрбум төгрөгийн Сангийн яамтай байгуулагдаагүй урт хугацаат зээлийн асуудал байгаа юм. Компаниуд дээр байгаа 61 тэрбум төгрөгийн зээл төлөгдөөгүй, зээлийн хуваарийнхаа дагуу төлөгдөөгүй гэдэг нь 25 оны Засгийн газрын 132 дугаар тогтоолоор 25 онд дулааны үнэ, тариф индексжих байсан асуудлыг 26 оны 01 сарын 01 хүртэл хойшлуулсан. Үүнтэй холбоотой салбарын 1 худалдан авагч дээр 224 тэрбум.../минут дуусав./

Да.Цогтбаатар: 6 номерын микрофоныг нэмж өгье.

Б.Ерэн-Өлзий: 224 тэрбум төгрөгийн орлогын дутагдал үүссэн болохоор Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ, Улаанбаатар дулааны сүлжээ, Цахилгаан дамжуулан үндэсний сүлжээ, Эрдэнэт, Булганы цахилгаан түгээх сүлжээ гээд эдгээр компани маань Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн урт хугацаа томоохон зээлээ тухайн оны хуваарьт зээлээ төлж бол чадаагүй. Үүнтэй холбоотой энийг бол 61 тэрбум төгрөгийн өр төлөгдөөгүй байна гэж үзсэн.

226 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдлийг Сангийн яамтай актаар баталгаажуулаагүй гэсэн. Энэ нь юу байгаа юм гэхээр Тайширын усан цахилгаан станцыг барьсан зээл, Эгийн голын усан цахилгаан станцын төслийн судалгааны зээл, Алтай, Улиастай баруун бүсийн түгээх сүлжээний шугам сүлжээг өргөтгөж авч хэрэгжүүлсэн Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрүүд байгаа юм.

25 оны 07 сарын 30-ны Засгийн газрын 30 дугаар. тогтоолоор Баруун бүсийн эрчим хүчний системийн компаниудад бүтцийн өөрчлөлт хийсэнтэй холбогдуулан эдгээр компани.../минут дуусав./

Да.Цогтбаатар: Дараагийн асуулт. Энэ Заяабал гишүүн, дарга түрүүн энд Наранбаатар дарга 2 сууж байсан юм. Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хоёр хамтраад хаалттайгаар Монголбанкнаас гаргаж байгаа тэр сан, хөтөлбөрүүдтэй холбоотой мэдээллүүд дээр мэдээлэл авъя гээд Монголбанкны Ерөнхийлөгчийгөө урьж залаад дийлээгүй хурал хойшилсон. Өнөөдөр бас Монголбанкны Ерөнхийлөгчийг хуралдаа урьсан боловч бас ирсэнгүй.

Тэгэхээр энэ ингээд тэр Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хоёрын хамтарсан хуралдаан явсны дараа бид нар эцсийн дүгнэлт гаргах уу? Эсвэл тэр Байнгын хороодын хуралдааныг явчихсан гэж тооцоод шийдвэр гаргаад явчих юм уу? Энэ дээр Улсын Их Хурлын Тамгын газраас хариулт байна уу? Хариулах хүн байхгүй юм уу? Хамтарсан хуралдаан байсан яваагүй юм. Монголбанкны Ерөнхийлөгч нь хүрэлцэн ирээгүй. Байхгүй энэ Эдийн засгийн

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байнгын хорооны сонсгол дээр Анар нэр дэвшигч ганцаараа сууж байгаа. Монголбанкны, одоо чинь манайх Монголбанк 1 Ерөнхийлөгчтэй, дэд ерөнхийлөгчтэй. Хугацаа нь дуусчихсан. Тэгээд аль аль нь ирээгүй. Улсын Их Хуралд ингээд хүндэтгэлгүй ханддаг. Энэ асуудлыг тодруулчихаад дараагийнхаа ажил руу орёе.

Сангийн яамнаас би дахиад асуулт байна байж байгаарай. Энэ нийслэл дээр 7 их наяд төгрөгийн алдагдал үйлдвэрлэгдсэн байгаа. Энэ дээр Сангийн яам зарчмын хувьд ямар байр суурь барьж ажиллаж байгаа вэ?

2 номер хариулъя. Сангийн дэд сайд.

Б.Хулан: Нийслэлийн асуудлыг ажлын хэсэг.

Да.Цогтбаатар: Байж байгаарай цагийг нь эхнээс нь явуулахгүй бол нэлээн цаг нь явчихлаа. Эхнээс нь 2 номерын микрофоны хариултыг өгье. 1 номерын микрофон дээр хариулт өгье.

О.Хуягцогт: Нийслэлийн төсөв дээр ер нь сая төсвийн тусгай шаардлагад хангахад орон нутгийн төсөв дээр үүсэж байгаа харилцаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, бусад хууль тогтоомжоор заасан энэ шаардлагуудыг зөрчихөд нөлөөлж байна гэсэн ийм дүгнэлт Үндэсний аудитын газар, энэ Сангийн яамнаас бол энэ дээр 25 оны хэрэгжиж байгаа энэ суурь тэнцлийн тусгай шаардлага алдагдахад энэ асуудал нөлөөлж байна.

Ингээд энэ нь бол 25 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр орон нутаг дээр 500 тэрбум төгрөгийн ийм алдагдал үүссэн. Энэ дээр бол нийслэлийн алдагдал бол гол нөлөөлсөн байгаа. Тэгэхээр энийг бол төсвийн энэ хууль тогтоомжийн шаардлагуудын нийцэл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль төсвийн хүрээний мэдэгдлийг хангадаг байх чиглэлээр судалж, дараагийн төсвийн, ирэх оны төсвийг өргөн барихад бол холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийг судалж оруулж ир.../минут дуусав./

Да.Цогтбаатар: Баярлалаа. Одоо үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Түвшин гишүүнээр. Би бас кнопоо дарж болохгүй юу? Дарахгүй болохоор чинь ингээд дэг зөрчлөө гээд шүүмжлэл ирээд байгаа юм. Дараад нь ингээд хэлдэг юм байна Батжаргал даргаа. Лувсанжамц гишүүнээр тасаллаа. Эрдэнэбат гишүүний нэрийг оруулъя. Та ирцдээ бүртгүүлчихсэн үү? Дарахаар орохгүй байна уу? Дарчих дарчих хүлээж байна. Таслаагүй байгаа. Эрдэнэбат гишүүнээр тасалбар болголоо. Батжаргал гишүүний микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Гишүүд төсвийн шууд захирагч нар холбогдох төсөв санхүүгийн албадын энэ өдрийн амар амгаланг айлтгая. Бид хэд улсынхаа 2025 оны төсвийн гүйцэтгэлийг ярьж байна. Анхаарах ёстой олон асуудлууд байгаад байгаа бидэнд үнэхээрийн. Улсын эдийн засаг төсөв үнэхээрийн томорч, тэлж байгаа. Энийг дагаад бид энэ эрх зүйн орчин талдаа бодитой дүн шинжилгээ хийж, шинэчлэл хийхгүй бол болохоо байчихаад байгаа юм. Төвлөрсөн төсөв, орон нутгийн төсөв хоёр чинь хоорондоо яаж харилцах юм бэ, яаж төлөвлөгдөх юм бэ, яаж гүйцэтгэл гарах юм бэ, яаж хариуцлагын механизм байх юм бэ? Төсвийн

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

тусгай шаардлагуудаа хангуулахын тулд орон нутгийн төсвийн ямар үзүүлэлтүүд дээр хязгаарлалт тогтоох ёстой юм бэ гээд бодох юмнууд олон байгаа. Зайлуул энд тайлан бариад ороод ирчихсэн гэдэг юм уу, нэгтгэл гаргаад ороод ирчихсэн улсын буруу биш байхгүй юу.

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд төсвөө баталдаг эрх нь байж байгаа. Тэнд өөрсдийнхөө орлогын боломж гэдэг юм уу, үлдэгдлүүд дээрээ тулгуурлаад зардлынхаа төлөвлөлтийг хийчхэж байгаа. Гэтэл энд бид нар урсгал төсвийн тэнцлийн тухай асуудал яригддаг, төсвийн тэнцлийн тухай асуудал яригддаг, алдагдлын тухай ярьдаг. Энэ тоо чинь баригдахгүй шүү дээ. Угаасаа эрх зүйн орчин нь тийм юм чинь. Тэгэхээр үүнийг нэг мөр харж энэ ачаагаа үүрч байгаа Сангийн яам асуудлаа нэг мөр оруулж ирэх шаардлагатай.

Дараагийн зүйл бид нар үеэ бодвол бас ний нуугүй үнэнийг хэлэхэд Баялгийн сан ч гэж байна, Хуримтлалын сан ч гэж байна, Хөгжлийн сан ч гэж байна, тодорхой бас мөнгөжүүлэлтийн сангууд үүсээд байгаа юм. Энэ сангуудыг хэдүүлээ төлөвлөлт, зарцуулалт, өгөөж энэ юмнуудыг яаж баталгаажуулж хараа хяналтдаа байлгаж сайжруулах ёстой юм бэ? Үүнийг анхаарлаа хандуулж ярихгүй бол өмнөхүүдтэй адил тодорхой хэмжээний хуримтлалууд банкны системээр дамжаад бүдгэрч байгаа энэ тэртэй ижил ийм зүйлүүд гарах магадлал өндөр байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг бид эрх зүйн хувьд нь зөв зохицуулж янзлахгүй бол болохгүй. Үүнийгээ шийдмээр байна.

Дараагийнх нь энэ төрийн өмчтэй аж ахуйнуудын асуудал. Үүнийг хэдүүлээ өмчөө ард түмнээ төлөөлж дээд шийдлийг нь гаргаж байгаа эрх нь Их Хуралдаа байгаа юм бол ядаж Засгийн газар тусгайлсан байдлаар тухайн жилийнх нь аж ахуйн, төрийн өмчийнхөө бодлого, чиглэл, орлого, зарлага, ашигт ажиллагааны түвшин энэ юмнуудаа оруулж ирж хянуулдаг байх ёстой. Буцаагаад тайлагнадаг байх ёстой. Энэ нь эрх зүйн хувьдаа бас бид илүү баталгаажуулах ёстой. Одоо ТУЗ, ТУЗ л гээд яриад байгаа. Яг нарийндаа ТУЗ-ийг бид нар өөрсдөө удирдлага даалгавраар хангахгүй байгаад байгаа шүү дээ яг үнэнийг хэлэхэд. Тэнд ямар шийд гаргаж байгааг нь төдийлөн анзаарахгүй яваад байгаа байхгүй юу. Тэр ТУЗ эндээс тов тодорхой хий.../минут дуусав./

Да.Цогтбаатар: Батжаргал даргын микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Тусгай шаардлага гэдэг шиг хэдэн үзүүлэлтийг тогтоож авч тэр дээр түвшин тогтоож өгөхгүй бол болохгүй болчхоод байгаа юм. Тэгж байж энэ чинь нэлээн тийм эмх цэгцтэй явах тухай асуудал байх юм байна гэж.

Дараагийн нэг асуудал нь энэ бүтээн байгуулалтын чиглэлээр дуусаагүй үйлдвэрлэлүүд нэлээдгүй байгаад байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн энэ ажлуудыг дуусгах тухай асуудал байна. Энэнээс хамаараад хөрөнгийн өгөөж гэдэг юм уу энэ юм их муудаж байна. Дан дамаа энэ гадаадын зээл ашиглалттай холбоотой маш тааламжтай гэдэг юм уу, хямд өртөгтэй зээл гэж яриад байдаг. Гүйцэтгэлийн ажил удаашрах тусам дуусаагүй үйлдвэрлэлд автсан зээлийн хүүд төлж байгаа төлбөр тэнд бүрдүүлчихсэн эх үүсвэрийг авч ашиглаж чадаагүйн төлөө төлж байгаа шимтгэл хоёрынхоо нийлбэрээр зээлийн чинь өртөг өндөрсөөд байгаа байхгүй юу.../минут дуусав./

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Да.Цогтбаатар: Батжаргал даргын микрофоныг өгье. Байж байгаарай асаагүй байна. Асчихлаа.

Ж.Батжаргал: Саяын ярьсан 4 чиглэлийг төсвийн гүйцэтгэл батламжилсантай холбогдуулж авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тогтоол руу оруулчихмаар байна агуулгаар нь. Тэгвэл бас энэ улс орны төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хариуцлага, сахилга энэ юманд хэрэгтэй болов уу гэж бодоод байх юм. Баярлалаа.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Бид нар нөгөө төсвийн гүйцэтгэлээ 133 төгрөг гэж захиран зарцуулж байгаа нийт мөнгөнийхөө асуудлыг ярьж байгаа учраас Төсвийн зарлагын хяналтын хороонд өнөөдөр жишээлэхэд 7 гишүүн ажилдаа ирсэн. Ирцдээ орсон. Бусад гишүүд нь өөр хурал давхардаад явж байх шиг байна. Тэгэхээр энэ цөөхөн ч гэсэн гишүүдийнхээ хэлж байгаа үгнүүдийг маш сайн гүйцэд сонсож аваад цаашдынхаа ажил дээр бас сайжруулах сайжруулах чиглэлд анхаарвал гэж бодоод микрофоныг бол маш сайн өгөөд байгаа шүү гэдгийг бас зөвөөр ойлгоорой.

Түвшин гишүүний микрофоныг өгье.

Б.Түвшин: Төсвийн гүйцэтгэлийн асуудал дээр энэ тогтоолд оруулах сая Батжаргал даргын хэлсэн 4 саналтай зарим нь давхцаж магадгүй. Тэгэхлээр ер нь бол төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүүг бууруулах ажлыг санаачилж хийх хэрэгтэй. Төсөв хэлэлцэж байх үед орлогыг хэт өндрөөр тавиулаад тэгээд дараа нь хөрөнгө оруулалтын, хөрөнгийн зардлаа бууруулах замаар урсгал зардлын орлогод эзлэх хувийг нэмэгдүүлэх ийм үйл явц л миний мэдэхийн сүүлийн 2, 3-н төсөв дээр харагдаж байгаа. Тийм учраас энд хариуцлагын асуудлуудыг ярих ёстой. Ер нь бол төсвийн хүрээний гүйцэтгэлийн зөрүүг тэр Пи Эф Эй-ийн 5 хувийн босгын хэмжээнд хүргэх энэнээс илүү гарах юм бол хариуцлага тооцдог болгох зайлшгүй шаардлагатай байгаа.

Хоёрдугаарт, тэр суурь тэнцлийн шаардлага, төсвийн хүрээний сахилга батыг бэхжүүлэх хүрээнд ажил хийхгүй бол болохгүй. Үүнийг бас тогтоолын төсөлд зайлшгүй оруулах ёстой. Магадгүй Их Хурлын болон Тамгын газрын дэргэд бие даасан тийм төсвийн зөвлөл бас байгуулж шаардлагатай, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл энэ тэрийг оруулаад явах ёстой. Тэгэхгүй бол энэ суурь шаардлагууд 1 л өдөр хэтрээд явчихсан орон нутгийн болон улсын төсөв гээд бие биелээгүй чихээд сууж байдаг ийм асуудлууд үүсэж магадгүй байна.

Гуравдугаарт, өрийн эрсдэлийн удирдлага, дотоодын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх талаар бол энэ тогтоолын төсөл зайлшгүй шаардлага хэрэгтэй. Ялангуяа энэ гадаад зээлийн төслүүдийг ингээд бэлтгэл ажлыг зээлийн гэрээ байгуулахаас өмнө хийхгүй бол бэлтгэл ажилгүй хийгээд гадаадын зээл авчихдаг тэгээд ашиглаагүй зээлүүд дээрээ хүү төлөөд явдаг энэ асуудлыг бол бас тогтоолын төсөл дээр хийж цаашдаа зогсоох ёстой.

Дөрөвдүгээрт, урсгал зардлын бүтцийг оновчтой болох хэрэгтэй. Ер нь бол нэгдсэн төсвийн урт хугацааны урсгал зардлын иж бүрэн шинжилгээг хийлгэж, тэгээд энэ татаас, шилжүүлгийн үр дүнгүүдийг дүгнэдэг байдлаар ингээд явах хэрэгтэй. Цаашдаа энэ цалингийн бүтцүүдийг бол нарийн, тодорхой задлах зайлшгүй шаардлагатай байгаа байх.

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тавдугаарт, төсөв, хөгжлийн төлөвлөлтийн уялдаа болон үр дүнд суурилсан гээд манай хэд ч бас ярьж л байх шиг байна. Үр дүнд суурилсан төсөв рүү шилжихгүй бол хэдүүлээ болохгүй нь гэж байна. Энэ бол оруулах ёстой. Тэгэхдээ Пи Эф Фи болон OCDE-гийн зарчимд нийцүүлээд тэгээд энэ төсвийн уялдаа, гүйцэтгэл үр дүнгүүдийг хийж, үр дүнд суурилсан төсөвлөлтийн хүрээг яг ингэж бүрэн нэвтрүүлэхгүй бол энд яг хэсэгчилсэн байдлаар бол энэ төсвүүд яваад байна гэдгийг бол бас хэлье.

Төсвийн дунд хүрээний хугацааны төлөвлөлт буюу төсвийн хүрээний мэдэгдлийг нийгмийн халамжийн шинж чанартай болон тодорхой төрлүүдээр дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувиар нь яг тогтоож өгөөд тэрнээс дээш гаргахгүй гэдэг байдлаар илүү бэхжүүлж, хамгаалахгүй бол тодорхой нэр төрлийн урсгал зардлууд нэмэгдсээр л байгаад байгаа.

Тийм учраас энэ цалин, халамж бусад бүх төрлийн зардлуудыг хийж төсвийн хүрээний мэдэгдлийг 15-17 үзүүлэлттэй болгож, дахиад тодотгол хийдэггүй болгох ийм эрх зүйн зохицуулалтыг авч байж энэ төсөв чинь өөрөө гүйцэтгэл сайтай болоход. Тэгээд түрүүний миний дурдсан төсвийг 3 дамжлагатайгаар хэлэлцэх ёстой. Төрийн өмчит компаниудын байдал, төсвийн бусад байгууллагууд болон нэгдсэн төсөв гэсэн ийм байдлаар хэлэлцсэн. Энэ бүгдийг бол тогтоолын төсөлд оруулна уу гэж шаардаж байна.

Да.Цогтбаатар: Түвшин гишүүнд баярлалаа. Булгантуяа гишүүний микрофоныг өгье.

Х.Булгантуяа: Би ийм хэдэн санал хэлэх гэсэн юм. Нэгдүгээрт бид нар би ч гэсэн дэд сайд байхдаа зөндөө л олон төсөв хэлэлцүүлж байлаа. Тэр үед Валютын сангийн хөтөлбөртэй гээд 1 жилд битгий хэл 2, 3-н ч төсөв хэлэлцдэг байлаа. Бид нар төсвөө батлаад л тухайн үедээ шаагаад л тэгээд л ерөнхийдөө мартчихаад байдаг.

Тэгээд би нэгдүгээрт Төсвийн зарлагын хяналтын дэд хороон дээр, Төсвийн байнгын хороон дээр зөвхөн 1 жилийн төсөв яриад явах биш Байнгын хороод ч гэсэндээ бүүр 5 жилээс 10 жилийн хугацаанд бид нар юун дээр хэчнээн их төгрөг зарцуулсан юм, тэр нь яг ямар үр дүнд хүрсэн юм гэдгийг бүүр тендацыг нь хармаар байгаад байгаа байхгүй юу. Ганц ганцхан жилээр нь биш. Тэгж байж бид нар бид нарын барьж байгаа өнөөдрийн бодлого зөв үү буруу юу? Өнгөрсөн 5 жилд, 10 жилд барьсан бодлого зөв үү, буруу юу, үргэлжлүүлээд энийг хэрэгжүүлээд яваад байх нь зөв үү, буруу юу гэдэг дээр анализ хийхгүй бол буруу байгаад л байхад олигтой үр дүн гарахгүй байгаад л байхад үргэлжлүүлээд л 10 жил тэрүүнийгээ санхүүжүүлээд байна гэдэг бол маш утгагүй. Тэгэхээр үүн дээрээ нэгдүгээрт дүн шинжилгээ хийж хармаар санагдаж байна.

Тэгээд миний бодлоор Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргаа үүн дээр магадгүй нэн чухал гэсэн зарим асуудлууд дээр бүүр тийм чиглэл өгмөөр байгаа юм. Сүүлийн 5-10 жилд энэ энэ энэ гээд олон сэдэв бол жоохон хэцүү байж магадгүй. Тэгээд Үндэсний аудитаа оруулж байгаад энэ тэр бүүр ингээд үр дүнг нь үзээд.

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Жишээлбэл, ядуурлыг бууруулахад бид сүүлийн 10 жил хэдэн төгрөг зарцуулсан юм, тэгээд яг ямар үр дүн гарсан юм, яг ядуурал нь хэдэн хаана яаж буусан юм? Хэрвээ болохгүй байгаа бол наадах чинь ядуурал дээр хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүд чинь болохгүй байна гэсэн үг байхгүй юу гэх мэтчилэн бид нар ийм 1 жилийн алдагдлын тоог яриад л.

Би одоо яг бодит үнэнийг хэлэх үү ирэх жил өдийд дахиад л мартчихсан сууж байна. 25 онд юу боллоо санахгүй. 26-нд ямар төсөв баталлаа тэрүүнийгээ батлахад бүгдээрээ улс орон даяараа яриад л тэгээд л гүйцэтгэл ярихад ийм цөөхүүлээ сууж байж яриад л тэгээд л бараг дуусчхаад байдаг юм.

Тэгэхээр 1, 2 жил заримдаа төсвийн үзүүлэлтээ сайнтай, муутай байж болно. Гэхдээ жишээлбэл Австрали улс 3 Р буюу “population” хүн амын өсөлт нь сайн байгаад, “participation” буюу ажиллах хүчний оролцооны түвшин сайн байгаад, “productivity” буюу бүтээмж нь сайн байх юм бол 1, 2 жилдээ төсөв алдагдалтай байсан ч гэсэн манай улс зөв чиг хандлага руу явж байна. гэж өөрөө өөрийгөө дүгнэдэг. Ард түмэн нь өсөөд, ажил хөдөлмөр эрхлээд, дээрээс нь нэмээд их бүтээмжтэй ард түмэн байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ улс бол өрсөлдөх чадвартай ийм мундаг улс болж байна гэсэн үг.

Манай улсын хувьд бол ямар байгаа гэж энд яг гол яамныхан сууж байна. Хүн ам нь гайгүй өсөж байна. Тэгэхдээ хүн амын өсөлтийн хурд саарч байна. Ажиллах хүчний оролцооны түвшин ялангуяа эмэгтэйчүүдийн дунд эд нар бол буурч байна. Ингээд манай бүтээмж бол зүрхний цохилт шиг өсөлттэй, бууралттай.

Тэгэхээр өөрөөр хэлбэл бид нар их ажил эрхэлдэггүй, тэгэхдээ ард түмнийх нь хүн амынх нь тоо нь өсөөд, бүтээмж нь сайнтай, муутай ийм ард түмэн байх юм бол ирээдүйн хөгжил жоохон хүнд харагдах гээд байна. Тэгээд би Байнгын хорооныхоо гишүүдэд, Зарлагын хяналтын дэд хорооны даргад бас хэлэхэд нэгдүгээрт төсөв хэлэлцэх, улсын төсөв хэлэлцэх үе шатыг буурууллаа гэж гэдэг юу явж байгаа юм байна Улсын Их Хурлын дэгийн тухай хууль дээр. Би бол намар та бүхэн төсвөө оруулж ирээд л 1 хоног байна уу, 2 хоног хэлэлцээд л тэгээд л шууд хэлэлцэхийг нь дэмж гээд бид нар кнопдуулах гээд байгаа байхгүй юу. Бид нар арай гэж асуулт асуугаад 1, 2-хон хоногийн өмнө том номоо өгдөг юм. Аудитын тайлан энэ тэрийг. Бид нар уншиж амжихгүй байж байж тэрүүнийг шууд дэмжих болчихоод байгаа юм.

25 оны төсөв дээр үүнээс үүдээд хориг тавигдаж байсан. Тавьчихсанаа, хэлэлцэх эсэхийг нь дэмжсэнийхээ дараагаар үгүй ээ энэ чинь асуудалтай байна шүү дээ гэж хэллээ гэхэд тэр нь дэндүү оройтчихсон байгаад байдаг. Тэгэхээр яг үүнтэй адилхан нөхцөл байдал үүсэхгүйн тулд уг нь бол эхний 1 удаа бүх Засгийн газрын сайд нараас, төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асуугаад үүний дараагаар танилцаад.../минут дуусав./

Да.Цогтбаатар: Булгантуяа гишүүний микрофоныг өгье.

Х.Булгантуяа: Бид нар чинь бас энд өөрөө өөрийгөө төлөөлж сууж байгаа биш сонгогдсон тойргоо, төлөөллөө, байгууллагуудаа төлөөлж байгаа учраас тэнд очиж хэлэлцүүлэг хийгээд за болж байна уу гээд буцаж ирээд та бүгдийн ирэх жил төлөх гэж байгаа татварыг чинь, цуглуулах гэж байгаа, та нараас авах гэж байгаа цуглуулах гэж байгаа мөнгийг ингэж зарах гэж байна. Болж байна уу гээд ингээд

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

санал хураалтдаа оролцъё гээд уг нь Улсын Их Хурлын дэгийн тухай хууль дээр төсөв хэлэлцэхтэй холбоотой харилцааг арай жоохон тавиу бөгөөд оролцоотой, нээлттэйгээр хэлэлцэхээр ингээд хийж өгсөн.

Одоо үүнийгээ буцаад болиулъя гэж байх шиг байна. Би бол эхлээд төсөв эхнээс нь хэлэлцэх дэг сайн байж байж үүний дараа хэдүүлээ гүйцэтгэл ярих ёстой гэж бодож байна. Одоо буцаад л ингээд л орох юм бол ирэх жил хэдүүлээ 2 хоногийн дотор гялс сонсоод л тэгээд заримдаа шөнөжин, өдөржин шөнийн 12 цагт ямар иргэн тэрүүнийг сонсоод сууж байх юм бэ. Энэ чинь иргэдээс цуглуулсан мөнгөө үрэх гэж байгаа юм бол ажлын цагаар ард түмний анхаарал дунд, хяналт дунд энийг сонсох ёстой гэж бодож байна. Тэгээд нэг хэлэлцүүлгээ хийсэн.../минут дуусав./

Да.Цогтбаатар: Булгантуяа даргын микрофоныг өгье.

Х.Булгантуяа: Ингээд хэлэлцүүлгээ хийсэн болоод ард түмний хараа хяналтаас ч хол, хэвлэл мэдээлэл нь ч тэр үед бараг аягүй бол ядраад яваад өгөх байх. Ингээд шууд одоо хэлэлцэх эсэхийг нь дэмжье гээд ингээд санал хураалт явагдаад л нэгэнт дэмжигдчихсэн тул түүнээс хойш бол буцаах ямар ч арга байдаггүй Улсын Их Хурлаас. Засгийн газар л өөрөө татдаггүй юм бол ингээд ямар ч боломж байхгүй ийм юм руу буцаж орох гээд байна дэд хорооны даргаа.

Тэгэхээр төсөв эхлээд боловсруулахаасаа авхуулаад, хэлэлцэхээсээ авхуулаад сайн байх ёстой шүү. Дээрээс нь би Төсвийн зарлагын хяналтын дэд хороон дээр бас нэг шүүмжлэлтэй хандах гээд байгаа нь 2025 онд чинь юу юуг дэмжих жил гэж зарлаж байлаа? Боловсролыг дэмжих жил гэж байсан санагдаад байх юм. Энэ жил нь билүү өмнөх жил чинь юуг дэмжинэ гэж байлаа? Ирэх жил эрүүл мэнд. Харин тийм бид нар санахгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр өнгөрсөн жил юуг дэмжинэ гэж байлаа тэрийгээ бас тойрч ярих ёстой байсан юм биш үү. Ямар тэрүүн дээр төлөв.../минут дуусав./

Да.Цогтбаатар: Зарчмын хувьд Булгантуяа дарга маш сайн үг хэлж байна.

Төсөв хэлэлцэх үе шаттай холбоотой дэг дээр өнгөрсөн жил өөрчлөлт оруулж явсан. Сая бол төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэхэд 2 үе шатаараа явъя. Тэгэхдээ 1 гишүүн асуулт асуух минутыг 10 минут, нэмэлтээр 5 минут гээд 15 минут хүртэл хэлэлцэх хуулийн төслийг өргөн барьсан.

Асуултад хариулахдаа бол сая нэлээн олон Сангийн дэд сайд жишээлэхэд микрофоныг нэлээн олон нэмж өгсөн. Яг энийг бол 1 асуултад 6 минут хүртэл хариулах байдлаар аль болох иргэддээ мэдээллийг нь өгье гэдэг байдлаар Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах саналаа өгсөн. Сая Улсын Их Хурал арай гүйцэт хэлэлцээд баталж амжсангүй гэдгийг бас иргэддээ хэлье.

Лувсанжамц гишүүний микрофоныг өгье.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе.

Нэгдүгээрт, Сангийн яамандаа захиас байна. 07 сарын 05-наас эхлээд та бүхэн маань төсвийн ерөнхийлөн захирагч нартаа удирдамж, төсвийн хязгаарыг хүргүүлнэ тиймээ? Тэр дээрээ шалгуур үзүүлэлтийгээ таван жилийн үндсэн

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

чиглэлийн шалгуур үзүүлэлттэй адилхан байхаар та бүхэн маань удирдамжаа явуулаарай гэж бодож байна. Намар төсвөө өргөн барихдаа тэрнийхээ дагуу л өргөн барина. Сая хөгжлийн төлөвлөгөө дээр бол заримыг нь хасаад өргөн барьсан зүйл байсан. Гэхдээ буцаагаад засчихсан байгаа. Тэгэхлээр төлөвлөгөө, төсөв, таван жилийн үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлт бүгд адилхан байх ёстой. Тэгж байж бид нар энэ үр дүнгүүдээ яг арга замаараа хэдэн төгрөг зарцуулаад үр дүн нь гараад байгаа юм уу, үгүй юм уу гэдгийгээ хэмжих боломжтой. Тэгэхлээр энэ дээрээ алдаа гаргахгүй байхыг хүсье. Энэ намрын төсөв өргөн барих үйл ажиллагаа дээрээ.

Хоёрдугаарт, өнөөдөр энэ төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэж байгаа дээр зөвхөн гишүүд гэлтгүй бас олон нийт хэвлэл мэдээллийн байгууллагууд анхаарлаа хандуулдаг байхыг хүсье. Ялангуяа төсвийн ерөнхийлөн захирагч нар маань бусад төсвийн ерөнхийлөн захирагч нар хэдэн төгрөг зарцуулаад ямар үр дүнд хүрч байгаа вэ гэдгийгээ бие биеийнхээ үр дүнг бас ажигладаг байгаасай гэж хүсэж байна. Аль яам нь илүү сайн ажиллаад байна аль нь төсвөө зарцуулсан боловч үр дүндээ хүрч чадахгүй байна гэдгийгээ бас харьцуулж хардаг байх хэрэгтэй болов уу гэж бодож байна. Та бид бүгд татвар төлөгч учраас жил болгоны төсвийн гүйцэтгэлээр төлсөн татвар маань юунд зарцуулагдаж байгаа вэ гэдгийгээ бүгдээрээ хардаг байх ёстой болов уу.

Гуравдугаарт, өнөөдөр хэлэлцэж байгаа энэ төсвийн гүйцэтгэлтэй холбогдуулаад гарах гэж байгаа Их Хурлын тогтоолын төсөл маш нямбай болсон байна. Баярлалаа.

Эдийн засаг, хөгжлийн яам сая хэлж байсан. Өнгөрсөн жилийн 113 дугаар Улсын Их Хурлын тогтоол байгаа. Сая хаврын чуулганаар баталсан 06 сарын 02-нд баталсан ирэх жилийн Хөгжлийн төлөвлөгөөний Их Хурлын тогтоол энэ хоёр маш чухал. Эдийн засаг, хөгжлийн яам бусад яамнууд ч гэсэн адилхан. Сангийн яам бас адилхан.

Энэ тогтоолын төсөл дээр байгаа 5 дугаар зүйл төрийн болон орон нутгийн өмчит компанийн цалин хөлсний тогтолцоог тухайн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, сая хэлсэн хөрөнгийн өгөөж гэх мэтчилэн. Бизнес төлөвлөгөө болон техник, эдийн засгийн зорилтот түвшний хүрсэн үр дүн, өрсөлдөх чадвар ба үйл ажиллагааны цар хүрээ, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөж зэрэг хүчин зүйлийг харгалзан гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэд үндэслэн тооцдог аргачлалд суурилан уян хатан тогтоох зохицуулалтыг бий болгож нэвтрүүлэх. Энэ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хийх ёстой ажил байна. Та хэд маань энийгээ боловсруулаад Байнгын хороон дээр бас энийгээ танилцуулаад өгвөл зүгээр болов уу гэж бодож байна.

6.А. дээр төсвийн гүйцэтгэлийн үр дүнг бодитой тодорхойлох, салбар бүрийн гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, ил тод, нээлттэй хэлбэрээр хэлэлцүүлэг хийдэг байх шаардлагад нийцүүлэн төсвийн гүйцэтгэлийг тайлагнах, төрийн аудитын байгууллага аудит хийх, тайлан дүгнэлт гаргах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, хэлэлцүүлж батлуулах хугацааны цаглаварт дүн шинжилгээ хийж, өөрчлөлт оруулах асуудлаар гэсэн ийм зүйлүүдийг Засгийн газарт даалгаж байгаа.

Тэгэхлээр ирэх жилээс эхлээд яг жинхэнээсээ бид нарын таван жилийн үндсэн чиглэлийг баталж байхад хамт баталсан 113 дугаар тогтоол буюу шалгуур

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

үзүүлэлттэй нийцсэн төсвийн гүйцэтгэл гэдэг зүйл орсон байгаа шүү. Хэдүүлээ хамтдаа алхам алхмаар энэ зарцуулж байгаа улсын төсөв буюу иргэдийн аж ахуйн нэгжийн төлсөн татварыг ямар үр дүн бид нар авчирч чадсан бэ, үгүй вэ гэдгийгээ ярилцдаг л хаврын чуулган байх ёстой гэж бодож байгаа. Тэгэхлээр энэ дээрээ аль аль талдаа хамтраад ажиллая гэж бодож байна. Амжилт хүсье.

Да.Цогтбаатар: Лувсанжамц гишүүнд баярлалаа. Эрдэнэбат гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэбат: Энэ 25 оны түрүү жилийн төсвийг ер нь уул нь эхний улиралд багтаад хэлэлцэж байвал уул нь их зүгээр байна.

Хоёрдугаарт жилдээ байж байгаад нэг бөөнөөр нь ярих биш энэ явцын тайланг ер нь бол хардаг баймаар байна. Олон нийтэд нээлттэй. Тэгэхээр энэ зүйл дээр манай Зарлагын хяналтын хороо бас анхаарч өгөөч ээ. Тогтоол дээрээ бас тусгаж өгвөл сайн байна.

Тэгэхгүй бол баахан төсөв татдаг асуудал байна. Сая би хөдөө орон нутгаар нэлээн явлаа. Хүү хаа гээд л 05 сарын сүүл гээд л ингээд л 06 сарын 01 гэхэд хийж амжаагүй. Бүр сүүлдээ сонсох нь албаар тэр нөгөө тендерийн гомдол, маргаан болгож байгаад, амжуулахгүй болгож байгаад төсөв татдаг ийм аргатай болчихсон гэдэг ийм байдалтай. Их Хурлын гишүүдийг хөдөө, орон нутгаар очингуут тийм ч төсөв татагдсан, ийм ч төсөв татагдчихсан, тийм ч зүйл, ийм өгөөч ийм ч өгөөч гэдэг ерөөсөө юу нь тасрахгүй болчихсон байгаа юм. Тэгээд энэ тал дээрээ манай төсвийн асуудал дээр жоохон арай өөрөөр ажилламаар байна.

Тухайлбал, ашиглалтын зардлын маш их гинжин хэлхээс өртэй болчихсон байж байна. Ашиглалтын зардлыг нь буцаагаад татчихдаг юм байна. Тэгээд нөгөө зардлыг нь эс үгүй бол таначихдаг юм байна.

Сургуулийн дулаан, цахилгааныг хэмнэ гээд байгаа юм уу, эс үгүй бол хүүхдүүдийнхээ тогийг унтраа, эс үгүй бол дулааныг нь 05 сарын 15 биш, 04 сарын 15-нд хаа гээд байгаа юм уу ийм зүйл болчихсон байна шүү дээ энэ чинь.

Хоёрдугаарт, тэр Хэмнэлтийн хуультай холбоотой жоохон засах юм байна. Хэтэрхий бас хэмнэлтийн хууль гээд ерөөсөө ингээд нөгөө тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил гээд тавьчихсан. Тэр дотор нь яг үнэнийг хэлэхэд төрийн захиргааны тэр тамгын ажилчид чинь ямар ч техник хэрэгсэл бараг байхгүй болцгоочихсон, авч чадахаа больчихсон ийм байдалтай байгаад байгаа.

Тэгээд энийг нь хэн оруулах юм, эс үгүй бол нөгөө Хэмнэлтийн хуулийг санаачлах гишүүд нь байгаад байдаг. Засгийн газар нь өөрөө юу гэж үзэж байгаа юм? Энэ тал дээр бол эргэж харах асуудал болчихсон байна.

Баахан царцсан барилгууд байна. 6 жил, 7 жил болчихсон. Сум болгонд ийм царцсан барилга байгаад байна. Араас нь хөөцөлдөж байгаа хүн ч алга. Тэгээд яадаг вэ гэхээр дахин засварын төсөв, тэгээд тэрийг нь магадалгаа, дараа нь аудитаар орно гээд нэлээн их төвөгтэй процесстой болчихсон. Энэ чинь явж явж татвар төлөгчдийн мөнгө л үнэ цэнгүй болоод үндсэндээ тэр босгосон барилгууд чинь ашиглалтын шаардлага хангахгүй бүүр эргээд нураах байдалтай болчихсон байж байна.

Тухайлбал, би сая Булган аймгийн Баян-Агт сум дээр очсон 6 жил орж байгаа барилга тэнд ажиллаж байгаа. Хүн ер нь алга. Төсвөө нэмж өгөхгүй бол энэ орохгүй гээд суучихсан гэх мэтчилэн ийм төсвийн үрэлгэн байж байгаа энэ төсөв санхүүгийн юутай холбоотой асуудлууд нь орон нутагтай нь ингээд ажиллах энэ тал дээр жоохон ажилламаар байна.

Дараа нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллаас бас хэлмээр байна. Хөдөлмөрийн аюулгүй байдлын зардал гээд л баахан мөнгө тавьсан. Одоо хагас жил болж байна. Гарч байгаа мөнгө байхгүй. Тэр мөнгийг чинь хадгалах биш зарцуулж, эрсдэлээс хамгаалж байх ёстой мөнгө байхгүй юу. Тэгээд сүүлдээ нийгмийн даатгал дээр яаж байна ерөөсөө бараг авахаа больчихъё, талыг нь хасчихъя, эс үгүй бол ажилгүйдлийн даатгал руу оруулчихъя гээд.

Би бол харин бүүр бичгээр авъя гэж бодож байгаа бүх агентлагуудаас. Ямар агентлагаас ямар хүмүүсийг ажлаас халаад Ажилгүйдлийн даатгалын сан чинь ачааллаа дийлэхээ байчихсан. Тал нь яг ний нуугүй хэлэхэд бол манай төрийн албаны нэг нэгийгээ халсан юмнаас болж орж байгаа. Одоо яаж байна вэ гэхээр ажилгүйдлийн даатгалын олгодог хоногийг нь багасгая гээд хууль орж ирж байна шүү дээ. Тийм учраас энэ дур зоргоороо энэ ажилтнуудыг халдаг, сольдог, хоморголон халдаг энэ асуудлууд дээр ер нь ямар хариуцлага тооцох юм бэ? Төр нь өөрөө Ажилгүйдлийн даатгалын санд ачаалал учруулдаг болчихсон.

Дараа нь хөдөлмөр эрхлэлт гээд. энэ асуудал байж байна. Тухайлбал, Хөвсгөл аймаг 137 мянган хүнтэй. Уул уурхай байхгүй. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд 2 тэрбум өгдөг байсан чинь талыг нь хасчихсан 1 тэрбум төгрөг. Тэгээд 1 тэрбум төгрөгөөр хэдэн ажлын байр бий болгох вэ дээ. Тэгэхээр энэ төсвийн энэ юу чинь ерөөсөө ингээд уялдаагүй, орон нутгийнхаа онцлогийг мэдэхгүй, ширээний цаанаас тоо, тэгийг хамаагүй хасдаг иймэрхүү л байдалтай байгаад байна нөхөд өө. 1 минутаа нэмээд авчихъя.

Да.Цогтбаатар: Эрдэнэбат гишүүнд минут нэмж өгье.

С.Эрдэнэбат: Тухайлбал, саяын хөдөлмөр гэхэд бол Өмнөговьд бол их наядаар нь төсөв яригддаг орон нутагт бол их сонин биш л дээ 1 тэрбум бол. Зарим тэр хойд уул уурхайгүй тийм аймгууд бол хүнд байна. Тийм учраас ийм төсвөө уялдуулах, орон нутагтайгаа санал, хүсэлтийг нь авах гэдэг зүйл дээр та бүгд маань бас ажилламаар байна гэдгийг хэлмээр байна.

Боловсролын юунаас хэлчихье. Боловсролын зээлийн сангаас 8000 хүүхдийн төлбөр төлөгдөөгүй хүлээж байна гэж байгаа юм. Энэ яг юунаас болчхов? Төсвийн буруу төлөлтөөс болсон гээд сайд нь яриад сууж байна. Одоо яах вэ жирийн малчны ядарсан тэр хүүхдүүд чинь төлбөрөө төлж чадахгүй, Их Хурлын гишүүн очихоор төлбөрийн дэмжлэг үзүүлээч нэхээд сууж байна шүү дээ.

Тийм учраас ийм ийм зүйлүүд дээр бол манай төсөв захирагчид маань бас ингээд бодит ажил, амьдралд нийцсэн ийм төсөв дээр ажилламаар байна гэдгийг бас хэлмээр байна.

Да.Цогтбаатар: Гишүүд үг хэлж дууслаа.

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайланг хэлэлцэж дууслаа.

Ажлын хэсэг байж байгаарай. Одоо хоёр дахь асуудалдаа орно.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Цогтбаатар танилцуулна.

12.48 цаг.

Хоёрдугаар асуудал. “Монгол Улсын 2025 онд Төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн саяынхаараа хэвээрээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.7-д шаардлагатай гэж үзвэл Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон “Улсын төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолын төсөл боловсруулж, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно гэж заасны дагуу “Монгол Улсын 2025 онд төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан. Та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Тэгээд тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Зарлагын хяналтын дэд хорооны дарга Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар танилцуулна. Шууд ярьчих уу.

Монгол Улсын Их Хурлын хурлаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж байгаатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороодоос гарсан санал, нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмж зэргийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.7 дахь хэсэгт заасныг баримтлан тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төсөл 3 заалттай.

1 дэх заалтаар “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасан 6 дэд заалттай.

Дэд заалтуудад Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитын тайланд дурдагдсан аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, нийтлэг болон давтан гарч байгаа

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

алдаа, зөрчлийг зөрчлийн бодит шалтгааныг судалж, тэдгээрийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх, төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулж ажиллахыг, мөн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн үйл ажиллагаа, засаглалыг сайжруулахтай холбоотой болон холбогдох хууль, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах асуудлаар санал боловсруулж танилцуулахыг Засгийн газарт даалгахаар тусгалаа.

2 дахь заалтаар Үндэсний аудитын газарт төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн олон жил дамнасан зээлийн үлдэгдэлд аудит хийх асуудлаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг даалгасан.

3 дахь заалтаар тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төсвийн байнгын хороонд даалгасан.

Тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан санал гаргах гишүүн байна уу?

Алга байна. Батжаргал дарга байна. Батжаргал даргын микрофоныг өгье. Эрдэнэбат гишүүн бас байна. Өөр? Түвшин гишүүн. Энд микрофон дээр ирэх үү? Болсон. Батжаргал гишүүнээр тасаллаа. Эрдэнэбат гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэбат: Энэ 1 дүгээр зүйлийн 4.Б гээд төрийн өмчийн компаниуд нь үндсэн үйл ажиллагаанаас бусад нийгмийн хариуцлагын хүрээнд зарлага, санхүүжилт гаргахгүй гэж байгаа. Хориглох, хязгаарлах юм энэ дээр ороод ирчхэж.

Тэгэхээр төрийн өмчийн компаниуд тодорхой хэмжээнд нийгмийн хариуцлага хүлээх ёстой шүү дээ. Нэг зүйлийг ярихад нөгөө ГОК-оос 100 тэрбум гаргуулаад хүүхдийн бүх, Монгол Улсын хүүхдийн гадаа бие засдаг асуудлын нойлыг нь санхүүжүүлсэн юм. Яах вэ тийм биш юм гэж бодоход тухайн орон нутагтаа гэдэг юм уу, тодорхой чиглэлээр, нийгмийн хариуцлагын хүрээнд төрийн өмчийн компаниудыг ингээд нийгмийн хариуцлагын хүрээнд зардал гаргах юмыг нь ингээд хязгаарлана гэдэг юмыг яриад сууж байдаг. Энэ чинь бүх компаниуд төрийн өмч байна уу, хувийн өмч байна уу бүгдээрээ тодорхой хэмжээний нийгмийн хариуцлагын хүрээнд зардал гаргах ёстой. Ажилтнууд, хүүхдийн сургалтын тэтгэлэг, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэд гээд. Хэт ингээд бас явцуураад байгаа. Төрийн өмчийн компаниуд ингээд л бүгдийг нь аваачаад л.

Яг бодит ажил амьдрал дээр очиход тухайн орон нутагт байгаа байгаа энэ компаниудаасаа тэгээд л жижиг сажиг орон нутгийнхаа төсөв нь тэртээ тэргүй хязгаартай төвөгтэй байгаа нөхцөлд бол би боломжийнхоо хэрээр яриад харин тэр дээр нь хяналт тавих ийм юмыг нь тавихгүй болохоор хэт ингээд бүгдийг нь ингээд бүүр Их Хурлын тогтоолоор хязгаарла гэдэг юм тавьж байгаа чинь төрийн өмчийн компаниуд нийгмийн хариуцлагагүй, нийгмийн хариуцлагын зардал хөрөнгийг огт гаргахгүй гэдэг ингэж хэт явцуурч бол болохгүй.

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Эргээд бид нар яг бодит ажил, амьдрал дээр хөдөө, гадаа, сум, орон нутаг ийм зүйлүүд дээр ингээд очиход бол төрийн өмчийн компаниуд харин тэрний оронд тэр шахаа, тендер гэдэг юм уу элдэв янзын юмныхаа зүйлийг бол харин хязгаарлах ёстой. Тэр данхгар орон тоогоо гэдэг юм уу ийм зүйлүүдээ хязгаарлах ёстой. Тэмцээн наадам, уралдааныг ингээд бүгдийг нь хаагаад хаячихсан. Яг ний нуугүй хэлэхэд хүүхдүүд нь гадаа тэмцээнд явъя ингээ гэхэд төрийн өмчийн компаниудаас л очоод л гуйдаг шүү дээ. Ганц онгоцны тийз, зардал даагаач гээд л. Бүүр олон улсын, олимпын төрлийн, бүс тивийн юунууд дээр чинь бас тэгдэг шүү дээ.

Тийм учраас энийг бол ингээд хаачихаар эргээд төрийн өмчийн компаниудаа араас нь нөгөө аудит, бусад байгууллагууд нь дарамталдаг. Тийм учраас хэт бас ингээд зөвхөн Их Хурлаас зөвшөөрсөн энэ тэр гэхээр тэгээд Их Хурал ярих юм уу нөгөө хүүхдийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийх зардлуудыг нь. Тэгэхээр би энэ энэ асуудлыг бол хэт ингээд бид нар Их Хурлын тогтоол дээр ингээд бүр нийгмийн хариуцлагын хүрээнд энэ тэр гээд ингээд тавьчихсан. Тэгэхээр яг энийг логикийг нь харах юм бол төрийн өмчийн компаниуд нийгмийн хариуцлагын зардал гаргахгүй ээ гэдэг л юмыг л хийх нь л дээ. Энэ чинь олон улсын жишиг хүртэл бүх компани, аж ахуйн нэгж, байгууллагууд тодорхой хэмжээний нийгмийн хариуцлагын хүрээнд гаргах зардал юмаа гаргана.

Гэхдээ энийг харин буруугаар ашиглаад байгаа юман дээр нь харин тодорхой хэмжээний хязгаарлалт гэдэг юм бол юм тавих ёстой байх. Энэ тогтоолыг харахаар яг л тэгж уншигдаад байна. Ямар ч зардал тийм юм гаргахгүй гээд.

Да.Цогтбаатар: Энэ дээр тодруулга хэлж болох билүү? Аливаа байгууллага төсвөө батлуулахдаа шаардлагатай зардлуудыг бүгдийг нь саяын Эрдэнэбат гишүүний ярьснаар ийм уралдаан, тэмцээн, ийм арга хэмжээ, эдгээрийг бид нар нийгмийн хариуцлагынхаа хүрээнд заавал батлуулах ёстой гэдгээ авч орж ирээд батлуулж байгаа тохиолдолд бол зөвшөөрнө.

Тэрнээс бусдаар та ч гэсэн сая үгэндээ хэллээ шүү дээ. Нийгмийн хариуцлага гээд зардал тавиад өгчихдөг. Тэрийг нь дур зоргоор үрээд байдаг байж болохгүй гээд. Тодорхой заагаад өгчихсөн зардлыг баталчихсан тохиолдолд бол энэ дээр хэн нэгэн аудит хүний муу үзэх гээд л араас нь ухаж төнхөөд яваад байгаа юм байхгүй. Батлагдсан төсвийнхөө хүрээнд хийж, хэрэгжүүлж байгаа ажил чинь хэр бодит үр дүнд хүрч байгаа вэ гэдэг талаас нь бас харвал зөв ойлголт нь очно гэж хэлэхийг хүсэж байна.

Батжаргал даргын микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Хоёрхон зүйл байна. Нэгдүгээрт энэ 4.А.Б хоёр дээр бид эргэж хармаар юм шиг байна. Үнэхээр л аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа компани юм бол арилжааны шинж чанартай юм явуулалгүй яадаг юм бэ энэ чинь тэр.

Харин үндсэн үйл ажиллагааныхаа чиглэлээс өөр юм л явуулж болохгүй. Бид ингээд төрийн өмчит компаниудыг нэг болохоор ашиггүй ажиллаж байна, менежмент муутай байна гээд яриад байх. Үгүй тэгээд өөрсдөө арилжаа, элдэв бусын юм эрхлэхийг нь хаачхаад байхаар чинь яаж юм явах юм. Тийм учраас

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

үүнийг тэр үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоос бусад гэдэг байдлаар “А”-гийн асуудал дээр яримаар байгаа юм.

“Б” дээр болохоор зэрэг хуульд зааснаас бусад байхгүй юу. Их Хурал зөвшөөрөөд ч байх юм биш ер нь яг нарийндаа. Хуульд зааснаас бусад тохиолдолд гэж байгаа. Жишээ нь Тавантолгой гэхэд Шивээ-Овоогийн гэдэг юм уу, Багануурын өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах гээд зөнд нь мөнгө гаргачихдаг байхгүй юу. Тэгж боломгүй шүү дээ. Угаасаа л тусдаа хуулийн этгээд ухаантай юм бол энэ чинь өөрийнхөө үндсэн үйл ажиллагааг эрхлээд тэр ашигт ажиллагааныхаа түвшин юмаа хангаад явж байх ёстой шүү дээ. Тэгэхгүй хаа хамаагүй зардал санхүүжүүлээд байдаг энэ юмыг хязгаарлах ёстой.

Да.Цогтбаатар: Батжаргал даргын хэлж байгаатай бас санал нийлж байна. Энд бас жижигхэн тодруулга хэлэхэд одоо энэ аудитын дүгнэлт дээр ч гэсэн байгаа. 2 их наяд төгрөгийн валютын ханшийн эрсдэл хүлээчихсэн байгаа юм. Дотоодын аж ахуйн нэгжүүд, төрийн өмчит аж ахуйн нэгжүүд.

Дээрээс нь зээлийн үйл ажиллагааг зөвхөн Монголбанк зөвшөөрөл өгч зээлийн үйл ажиллагаа явуулах хуультай шүү дээ бид нар чинь Банкны тухай хуулиараа. Гэтэл нэгэндээ зээл өгдөг, авдаг, эсвэл валютын ханшийнхаа эрсдэлийг өөрсдөө хүлээж удирдаж чадахгүйтэй холбогдуулаад энэ нөгөө хувийн хэвшилтэй өрсөлдөх арилжааны шинжтэй гэдэг энэ зүйл, заалтуудыг оруулж өгсөн. Тэгээд Эрдэнэбат гишүүн болон Батжаргал гишүүний хэлсэн саналуудаар зарчмын зөрүүтэй саналыг эцэслээд тэгээд тогтоолынхоо төслийг баталчихъя.

Зарчмын зөрүүтэй санал гаргасан. Эрдэнэбат гишүүний ярьдаг хэсэг бол дахиад энэ дээр байгаа. Төрийн байгууллага, төрийн өмчит компанийн засаглал, ил тод байдал, төсөв санхүүгийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, тухайн хуулийн этгээд хууль тогтоомжоор олгосон болон гэж байгаа юм. Энэ дотор чинь хууль тогтоомжоор нөгөө төлөөлөн удирдах зөвлөл нь юм уу, хувьцаа эзэмшигч нь та нар энэ зардлаа гаргаж болно гээд баталчихсан тохиолдолд нийгмийн хариуцлагын хүрээнд явах гэж байгаа спортын тэмцээн, урлагийн арга хэмжээ энэ тэр гэдэг юмнуудыг чинь бол батлаад явна түүгээрээ.

Тэрнээс энэ доор энэ 4.Б дээр орж ирж байгаа нийгмийн хариуцлагын хүрээнд гээд нийтлэг байдлаар задгай тавиад өгчихөөр Батжаргал гишүүн ч хэлж байна. Булгантуяа гишүүн ч хэлж байна. Бүгдээрээ хяналтгүйгээр үүрдэг юм. Аудит ч гэсэн тайландаа энийг тусгачихсан байгаа асуудал. Тэгэхээр энийг бас зөв ойлгоорой гэж хэлж байна.

Одоо зарчмын зөрүүтэй санал гаргасан учраас саналыг хураалгах юм байна.

Энэ Ганзориг гишүүн, Батболд гишүүдийг дуудаарай. Санал хураалт явагдах гэж байна. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Санал хураалтдаа бэлдээрэй. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Заяабал гишүүн. Бэлэн болсон гишүүд. Батжаргал гишүүн, Булгантуяа гишүүн, Заяабал гишүүн, Түвшин гишүүн, Цогтбаатар нарын 5 гишүүн. Батболд гишүүн санал хураалтдаа бэлдчихье.

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Санал хураалт. Саналын томъёоллыг уншиж танилцуулъя. Төсвийн гүйцэтгэлийн тогтоолын төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Улсын Их Хурлын гишүүн Түвшин гаргасан, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагыг зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох, шалтгааныг арилгах үүрэг даалгавар өгөх. Санал хураалт явуулъя.

85.7 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн санал Түвшин гишүүний санал. Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүүг арилгах гэнэ үү. Хоёрт нь суурь тэнцлийн шаардлага, төсвийн сахилга батыг бэхжүүлэх хүрээнд өрийн эрсдэлийн удирдлага, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх хүрээнд урсгал зардлын бүтцийг оновчтой болгох, төсөв, хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд улсын болон уншигддаггүй ээ, уялдаа болон үр дүнд суурилсан төлөвлөлтийг бэхжүүлэх чиглэлээр. Найруулга дээр оруулъя гэж байна. Санал хураалт. Санал хураалт хийх юм уу? Энийг тэгвэл найруулгаар явчихъя.

Дараагийнх нь. Энэ дараагийнх нь бас найруулга уу? Төсвийн гүйцэтгэлийг төрийн болон орон нутгийн өмчит компаниудын тайлан, аудит бусад төсөвт байгууллагуудын тайлан гүйцэтгэл, нэгдсэн тайлан, гүйцэтгэл гэсэн 3 үе шаттайгаар хэлэлцдэг болох. Санал хураалт. Улсын Их Хурлын гишүүн Түвшин.

57.1 хувиар саналаар дэмжигдлээ. Дахиад энд байгаа билүү?

Эрдэнэбат гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал 4.Б дэх заалтыг “Улсын Их Хурал зөвшөөрч шийдвэрлэснээс” гэснийг хасаж, “төсөвт байгууллагуудаас бусад” гэж өөрчлөх. Энэ ер нь бол шаардлагагүй санал. Санал хураалт.

Энэ санал хураалт яагаад гацчихав? Яваад гарсан үр дүн юм байна. Санал дэмжигдсэнгүй.

“Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэх нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Гишүүдийн саналыг нэмээд нөгөө таны саяын ярьсан найруулга энэ тэрээ хийгээд гэсэн үг шүү. Тэгээд санал хураалт явуулъя.

Санал хураалтад сая минийх гацчихсан. Би дэмжсэнээр ормоор байдаг. 71.4 хувь дээр санал дэмжигдсэн. Минийхийг бас дэмжсэнээр авъя.

“Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар танилцуулна.

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

“Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Оролцсон гишүүдэд баярлалаа.

13.07 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР